

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-17</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>18-60</i>

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	19
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах маягтыг батлах тухай/	19
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах товыг тогтоох тухай/	19-20
4.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	20-25
5.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	26-32
6.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/	32-58
7.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	59-60

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 11 дүгээр сарын 07-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 52 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Д.Өнөрболор;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, С.Ганбаатар.*

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, С.Бямбацогт, Э.Бат-Амгалан нар хуралдаанд оролцов.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Нийтийн өргөдлийг судлах ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлыг хойшлуулах талаар горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

8 дугаарт хэлэлцэх Нийтийн өргөдлийг судлах ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэлэлцэх асуудлаас хасав./17:55/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах маягтыг батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Одмандах нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах маягтыг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах товыг тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Одмандах нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн хүсэлтийг хүлээн авах товыг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 72.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Одмандах нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Одонтуяа, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 18 цаг 19 минутаас 19 цаг 59 минут хүртэл хуралдаан түр завсарлав.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хэлэлцэх асуудлын 7 дугаарт байгаа Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэх талаар горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хавдар судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ш.Раднаасэд, С.Одонтуяа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга, байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	6
Бүгд:	14

57.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
Гуравны хоёроор санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх:

“23.2.23.төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга, байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 1
Бүгд: 13
92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/-д тус тус даалгасугай:

1/орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах;

2/агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 0
Бүгд: 13
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 20 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Хавдар судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Төсвийн төслийн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй, сахилга хариуцлагын, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Үйлдвэржилтийн бодлогын, Хууль зүйн, Эдийн засгийн байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос Төсвийн байнгын хороонд тус тус ирүүлснийг Байнгын хорооны гишүүдэд тарааж танилцуулсан тул Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг сонссонд тооцёе гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	2
Бүгд:	14

85.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Байнгын хороодоос ирүүлсэн санал, дүгнэлтийг сонссонд тооцов.

Танилцуулга болон дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Даваасүрэн, Х.Баделхан, Ш.Раднаасэд, Ч.Хүрэлбаатар, Г.Амартүвшин,

Ж.Батжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Хавдар судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэхүү нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

1.Төсвийн орлого нэмэгдүүлэх санал:

Дүн: 590,761.3 сая төгрөг

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын Д.Тогтохсүрэн, Ш.Адьяа, П.Анужин, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баярсайхан, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.1.Олон жил хуримтлагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2022 оноос өмнөх хуримтлагдсан өр төлбөрийг 20-оос доошгүй хувь буюу **92,100.0 сая** төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 20-оос доошгүй хувь буюу **194,300.0 сая** төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг 50-аас доошгүй хувь буюу **256,361.3 сая** төгрөгөөр тус тус барагдуулж, улсын төсвийн орлогыг **542,761.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх.

1.2.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад зааснаас бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар тахлын үед төвлөрүүлээгүй ногдол ашгийн үлдэгдлийг бүрэн дайчлах замаар улсын төсөвт **48,000.0 сая** төгрөгийг нэмж төвлөрүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 5

Бүгд: 15

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн зардал нэмэгдүүлэх, бууруулах санал:

2.1.Төсвийн зардал бууруулах санал:

Дүн: 335,261.1 сая төгрөг

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, 2.1.1. Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 1.88 хувиар буюу **320,416.0 сая** төгрөгөөр бууруулах;

2.1.2.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай

холбогдуулан Эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг **25,738.2 сая** төгрөгөөр бууруулах;

2.2.Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал:

Дүн: 223,622.3 сая төгрөг

2.2.1.Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны урсгал зардлыг **1,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.2.Улсын төсвөөс Говьсүмбэр аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг **1,000.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.3.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгаж чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын орчныг бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг **25,388.2 сая** төгрөгөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг **350.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;

2.2.4.Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын Сум, багийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Төв аймагт **300.0 сая** төгрөг, Ховд аймагт **300.0 сая** төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх;

2.2.5.Аймгийн номын сангийн номын фондыг баяжуулах зорилгоор Соёлын сайдын төсвийн багцын номын зардлыг Төв аймагт **100.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.6.Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг баяжуулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын номын зардлыг **175.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.7.Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын 2016 оноос хойш нэмэгдүүлээгүй цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын цалингийн санг **233.0 сая** төгрөгөөр, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын цалингийн санг **640.5 сая** төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын цалингийн санг **11,100.1 сая** төгрөгөөр, Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцын цалингийн санг **198.1 сая** төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын цалингийн санг **17,506.1 сая** төгрөгөөр тус тус, нийт **29,677.8 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.8.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг **800.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.9.Ховд аймгийн агаар, хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын урсгал зардлыг **500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.10.Удирдлагын академид төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг **3,561.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.11.Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардалд зориулан Шадар сайдын төсвийн багцын урсгал зардлыг **500.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.12.Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг **8,108.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.13. 2024 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг **140,661.6 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.14.Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор аймгуудын тогтмол зардлыг 11,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.3.Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал:

Цэвэр өөрчлөлтийн дүн: 118,750.3 сая төгрөг

2.3.1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 9 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг хэрэгжилт, гүйцэтгэлийн явцтай уялдуулан **98,000.0 сая** төгрөгөөр саналын томьёоллын 1 дүгээр хавсралтын дагуу бууруулах.

2.3.2.Саналын томьёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан **800,889.4 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **245,012.9 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 212 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах.

2.3.3.Төсвийн төсөлд тусгагдсан 25 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **30,537.8 сая** төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **21,025.7 сая** төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **203,858.7 сая** төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **19,991.1 сая** төгрөгөөр саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт тусгасны дагуу тус тус нэмэгдүүлэх, мөн саналын томьёоллын 3 дугаар хавсралтын 4 дэх хэсэгт тусгасан 2 төслийн төсөвт өртгийг **34,992.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны санхүүжих дүнг **3,000.0 сая** төгрөгөөр бууруулах.

2.3.4.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн магадлалд хийсэн Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтэд үндэслэн саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 1 дэх хэсэгт тусгагдсан **284,078.1 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **18,604.3 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 51 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 2 дахь хэсэг дэх 61 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **115,698.0 сая** төгрөгөөр, 14 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **10,489.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томьёоллын 4 дүгээр хавсралтын 3 дахь хэсэг дэх 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнг **738.6 сая** төгрөгөөр тус тус бууруулах.

2.3.5.Төсвийн төсөлд тусгагдсан 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **7,773.8 сая** төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **5,873.8 сая** төгрөгөөр саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 51 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **71,820.7 сая** төгрөгөөр саналын томьёоллын 5 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу бууруулах.

2.3.6. Саналын томьёоллын 6 дугаар хавсралтад тусгагдсан **32,480.3 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **16,939.9 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төслөөс хасах.

2.3.7. Төсвийн төсөлд тусгагдсан төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 33 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадлыг **саналын томьёоллын 7 дугаар хавсралтад** тусгасны дагуу өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн, Г.Амартүвшин нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Бямбацогт, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төсвийн урсгал зардлыг бууруулах болон нэмэгдүүлэх саналын орлого, зарлагын тооцооллын зөрүүг гарган, эх үүсвэрийг зохицуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулах талаар чиглэл өгөв.

Гурав.Зарчмын бусад санал:

3.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах:

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.1.Төслийн 10 дугаар зүйлийн “1,231,447.7 сая төгрөг,” гэснийг “1,231,447.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 1
Бүгд: 14
92.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 3.1.2.Төслийн 11 дүгээр зүйлийн “2,788,332.7 сая төгрөг,” гэснийг “2,788,332.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах:

3.Ажлын хэсгийн гаргасан, 3.2.1.Төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийг “Төсвийн

ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” гэж, мөн хавсралтын 11.1 дэх хэсгийн “70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” гэснийг “70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” гэж, 11.2 дахь хэсгийн “Хөтөлбөр” баганын “11.2.1, 11.2.2” гэсэн дугаарыг “11.1.3, 11.1.4” гэж, 16.2 дахь хөтөлбөрийн 16.2.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “Илтгэх хуудас” гэснийг “Илтгэх хуудас-1” гэж, 20.5.1 дэх хөтөлбөрийн 20.5.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “7” гэснийг “300/7” гэж, 20.6.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “цэвэрлэгээний ажлын хэмжээ” гэснийг “цэвэрлэгээ” гэж, 21.1.2 дахь хөтөлбөрийн “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн” баганын “өргөжихийн хирээр” гэснийг “өргөжүүлж” гэж, 21.2.1 дэх хөтөлбөрийн “2024 оны зорилтот түвшин” баганын “5.0” гэснийг “6.0” гэж, 23.5.1 дэх хөтөлбөрийн 23.5.1.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “45,700.0” гэснийг “45,000.0” гэж, 23.8.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт баганын “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 26.6.1 дэх хөтөлбөрийн 26.6.1.5 дахь хэсгийн “Хэмжих нэгж” гэсэн баганын “жин” гэснийг “хувь” гэж, 28.3.1 дэх хөтөлбөрийн 28.3.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “51.1” гэснийг “65.3” гэж, 29.3.1 дэх хөтөлбөрийн 29.3.1.1 дэх хэсгийн “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 36.1.1 дэх хөтөлбөрийн 36.1.1.1 дэх хэсгийн “хамрагдаж” гэснийг “хамрагдсан хүмүүст” гэж, 37.1.1 дэх хөтөлбөрийн 37.1.1.1, 37.1.3 дахь хөтөлбөрийн 37.1.3.1, 37.1.3.3 дахь хэсгийн “хувь” гэснийг “явц” гэж, 38.1 дэх хэсгийн “70501 Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг” гэснийг “71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр” гэж тус тус өөрчлөх, хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орсонтой холбогдуулан дугаарлалтын өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, 3.2.2.Төслийн 1 дүгээр хавсралтын 11.2 дахь хэсгийн “70104 Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ” гэснийг, мөн хэсгийн “11.2” гэсэн дугаарыг, 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь хөтөлбөр буюу “Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилт, хүрэх үр дүнг 28.1.2.1, 28.1.2.2 дахь хэсгийн шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 28.4 дэх хэсгийн 28.4.1 дэх хөтөлбөрийн 28.4.1.3 дахь хэсгийн “Дорнод үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын явц” гэсэн шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 34.1.1 дэх хөтөлбөрийн 34.1.1.1 дэх хэсгийн “мянгаар” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, 3.2.3.Төслийн 9.1.3 дахь хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “төлөвлөгөөний” гэсний дараа “тухайн оны” гэж, 29.7.1 дэх хөтөлбөрийн 29.7.1.3 дахь хэсгийн “нээсэн” гэсний дараа “хүүхдэд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.3.Бусад санал:

Г.Тэмүүлэн: 1.Ажлын хэсгийн гаргасан, 3.3.1.Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томьёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, 3.3.2.Төсөлд зүйл, заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, 3.3.3.Төсөлд шинээр тусгагдсан төсөл, арга хэмжээний төслийн кодыг Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээс бэлтгэн төслийн 2 дугаар хавсралтын “Төслийн код” баганад харгалзуулан тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, 3.3.4.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврийн килограмм тутамд тоохон мөнгөн урамшуулал олгохоор төсвийн тооцоололд тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, 3.3.5.Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томьёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо:

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазарын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын “VI.I.8.Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 2,325.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 374.1 сая төгрөгөөр бууруулж, “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай/, төсөвт өртөг 374.1 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээ шинээр нэмж тусгах гэсэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо:

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10.Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 200.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын музейн засварт 2024 он, 200.0 сая төгрөг” гэж нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийн зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд

“Сэлэнгэ аймгийн соёлын салбарын тоног төхөөрөмжид 2024 он, 400.0 сая төгрөг” гэж нэмэх гэсэн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хууль зүйн байнгын хороо:

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж 1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын Х.3.2.1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын барилга, байгууламжийн их засварт тусгасан 6.4 тэрбум төгрөг дотор Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын үйлчилгээний барилгын нэмэлт ажлын төсөвт 423.8 сая төгрөгийг хуваарилуулах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал, 2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын Х.2.2.1.Хил хамгаалах салбарын их засварын санхүүжих дүнг 310 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын зардлаас 310 сая төгрөгөөр бууруулах, 3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XXI.Шүүхийн ерөнхий зөвлөлийн хөрөнгө оруулалтыг Хууль зүйн байнгын хорооны хянасан төсвийг хэвээр батлах буюу санхүүжих дүнг 52 тэрбумаар нэмэгдүүлж, IX.1.3.1.Монгол Улсын Сангийн сайдын санхүүжих дүнг 36 тэрбум, IX.2.3.1 дэх төсөл, арга хэмжээг 7 тэрбум, IX.2.3.2 дахь төсөл, арга хэмжээг 9 тэрбум төгрөгөөр санхүүжих дүнг бууруулах гэсэн Хууль зүйн байнгын хорооны дэмжээгүй саналуудаа татаж авав./22:20/

Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй санал:

Г.Тэмүүлэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, 2018-2023 оны хооронд 6 болон 7 жилийн цалингийн дунджаар тэтгэврээ бодуулсан 58 мянган иргэний тэтгэврийн нөхөн олговор 93,000.0 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт суулгаж, Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын Нийгмийн даатгалын сан, зээлийн хүүгийн төлбөр үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0.76 хувиар буюу 93,000.0 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 8
Бүгд: 13
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан, Сумын төв доторх 1,5 км хатуу хучилттай зам, Архангай, Хайрхан сум, 1.5 тэрбум төсөвт өртөгтэй 2024 онд 500.0 сая төгрөг нэмж, хуулийн төслийн 2 дугаар хавсралт дахь IX.1.3.1 дэх гаалийн шинэчлэл төслийн 2024 онд санхүүжих дүнгээс 500.0 сая төгрөг бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, 2020 оны төсвийн тухай

хуулийн XII.1.2.59-г заагдсан өв соёл, хүндэтгэлийн өргөө, Ховд, Үенч сумын үлдэгдэл санхүүжилтийг 40.924 сая төгрөгөөр 2024 оны оны төсөвт тусгаж, “Шинэ сэргэлт” Ховд, төслийн тоног төхөөрөмжийн санхүүжих дүнгээс 40.924 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 22 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хэлэлцэх асуудалтай холбогдуулан түр завсарлах горимын санал гаргав.

Хуралдаан 22 цаг 31 минутаас 23 цаг 37 минут хүртэл түр завсарлав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн референт Д.Отгонбаатар нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн саналыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “25,289.8” гэснийг “25,855.1” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “34.2” гэснийг “34.9” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2024 онд “-2,070.8” гэснийг “-1,505.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “-2,8” гэснийг “-2.0” гэж, Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2024 онд “6,170.4” гэснийг “6,273.3” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “8.3” гэснийг “8.5” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “2,389.6” гэснийг “2,351.9” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.
Хуралдаан 3 цаг 07 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 23 цаг 42 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим,
17 цаг 52 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Төсвийн байнгын хорооны гишүүддээ та бүхэндээ бас энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны гишүүдэд ирцийг танилцуулъя. Төсвийн байнгын хорооны хуралдаанд Амартүвшин гишүүн ирсэн байна. Булгантуяа гишүүн ирсэн байна. Одонтуяа гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Анандбазар гишүүн, Баделхан гишүүн, Даваасүрэн гишүүн, Хүрэлбаатар гишүүн, Батжаргал гишүүн, Жавхлан гишүүн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүдэд Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл буюу цаглавар батлах тухай,

2-т, Байнгын хорооны тогтоолын төсөл. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай,

3 дугаарт, Байнгын хорооны тогтоолын төсөл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн

сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай,

4 дүгээрт, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2023 оны 10 сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байгаа.

5 дугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд 2 дахь хэлэлцүүлэг байгаа,

6 дугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг байгаа.

7 дугаарт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд, эцсийн хэлэлцүүлэг байгаад байгаа.

8 дугаарт, Нийтийн өргөдлийг судлах ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт гэсэн асуудлыг оруулсан байна.

Ингээд ийм 8 асуудал байгаа. Энэ 8 асуудал дээр 1 санал байна. Энэ ажлын хэсгийн санал, дүгнэлтийг гаргах асуудлыг бас хэлэлцэх асуудлыг хойшлуулах саналтай байна. Энэ асуудал дээр ажлын хэсгийн санал, дүгнэлт болоод холбогдох тооцоо судалгаа одоогийн байдлаар дуусаагүй байгаа учраас энэ асуудлыг тодорхойгүй хугацаан дээр хойшлуулах саналтай байна.

Ингээд өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Тэгвэл саяын гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулна. Саяын хэлэлцэх асуудлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

17.56 цаг

2 дахь асуудалдаа орцгооё.

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Санал хураалт 72,7 хувиар дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталлаа.

Тогтоолын төслийг та бүхэнд бас мөн тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа бүгдээрээ орцгооё.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

1 дүгээр асуудал.

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Та бүхэнд цаглаварын төслийг бас хэлэлцүүлэхээр тараасан байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Санал хураалтад 8 гишүүн оролцож 72,7 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

17.57 цаг

“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлтсийн асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Дараагийн асуудалдаа орёе. 3 дугаар асуудал.

Та бүхэнд санал хураалтын дүнг танилцуулъя. 72,7 хувиар дэмжигдлээ.

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалт 63,6 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Жавхлан сайд дэмжсэнээр орох юм байна. Протоколд тусгаад аваад явъя.

17.58 цаг

4 дэх асуудалдаа оръё.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг сайд танилцуулна. Чинзориг сайдыг микрофонд урьж байна.

С.Чинзориг: Байнгын хорооны дарга, гишүүд ээ, Засгийн газраас Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж, Их Хуралд өргөн мэдүүлсэн. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19.9 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт эрүүл мэндийг дэмжих сан байна гэсэн ийм хуулийн зохицуулалттай. Одоо энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн

эх үүсвэрийг архи, тамхины онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь, тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хөрөнгөөс бүрдүүлж үйл ажиллагаа явуулж байна.

Одоогийн тусгай сангийн тухай хуульд байгаа 19.3 дахь зохицуулалтаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр зарцуулж байгаа. Тухайлбал нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажил зохион байгуулахаар хуульд тусгаж зохицуулж байгаа.

Одоо Засгийн газрын өргөн барьж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслөөр бол Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулахын зэрэгцээ 3 чиглэлээр зарцуулах бас хүрээг нь өргөжүүлж өгч байгаа.

1 дэх асуудал нь, энэ дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношлох, эмчлэх, шинэ технологи нэвтрүүлэх нутагшуулах бас зардлыг энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс санхүүжүүлдэг байхаар төсөлд оруулсан.

2 дахь асуудал нь, зайлиггүй шаардлагаар буюу энэ дотоодод оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнөөр гадаад улс орнуудад эмчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг байх асуудал энэ хуулийн төсөлд оруулж ирж байгаа. Одоо бид гадаадад зайлиггүй шаардлагаар эмчилгээнд хамрагдсан иргэдэд гадагшаа эмчилгээнд яваад ирсний дараагаар нь зардал төлбөрийнх нь тавхан хувийг олгодог. Энэ бол төр өөрөө дотооддоо оношилж эмчилж чадахгүй байна гэсэн өвчнөөр дотооддоо бас гадагшаа зайлиггүй шаардлагаар

эмчилгээнд явж байгаа иргэдэд тавхан хувийг олгоно гэдэг маш бас тийм бага байна гэж үзэж байгаа. Тийм учраас энэ гадаад эмчилгээний зардлыг үе шаттайгаар бас нэмэгдүүлэх нь бас зүйтэй гэж үзсэн.

3 дахь чиглэлээр энэ Нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгодог байх ийм зохицуулалтыг оруулж байна.

Энэ хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, мөн дотоодод оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношлох эмчлэх шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх зардлыг шийдвэрлэх, мөн бас зайлиггүй шаардлагаар гадаад улс оронд эмчилгээнд хамрагдсан иргэдийн санхүүгийн дарамтаас бас чөлөөлөх, оршуулгын тэтгэмж авах ийм нөхцөл боломжийг нь бүрдүүлж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Одоогийн байдлаар ер нь сүүлийн жилүүдэд Эрүүл мэндийг дэмжих санд улсын төсөвт тусгах сан маань 2-3 тэрбум тэрбум төгрөг л тусгаж зарцуулдаг. 2024 оны улсын төсөв дээр энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулаад Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн хэмжээг 5 дахин нэмэгдүүлж, 2024 оны улсын төсөв дээр Эрүүл мэндийг дэмжих санд 10 тэрбум төгрөг зарцуулахаар бас тусгасан. Ингээд түрүүний миний хэлдэг чиглэлүүд дээр захиран зарцуулах ийм чиглэлээр хуулийн төсөл боловсруулж оруулж байгаа юм.

Ингээд Байнгын хорооны гишүүдийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чинзориг сайдад баярлалаа. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя.

Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, Эрүүл мэндийн яамны Санхүү эдийн засгийн газрын Санхүү даатгалын хэлтсийн дарга Лхагважавын Мөнхцэцэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя.

Батжаргал гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн гишүүн асуулт асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ өргөн барьсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиас нэг зүйлийг тодруулъя гэж бодож байна л даа. Би ойлгохдоо энэ Засгийн газрын тусгай сангийн хуулиар тусгай сан байгуулах юм байна. Энэ нь голдуу нөгөө Монголд эмчлэгддэггүй эмчилгээний төлбөрийн асуудлыг шийдвэрлэх сан юм байна гэж ингэж ойлгож байна. Өнөөдөр Монголчуудын хувьд тулгамдаж байгаа хамгийн том асуудлын нэг нь энэ асуудал. Гадаадад их олон иргэн эмчлүүлж байна. Гэхдээ энд зориулаад их хэмжээний санхүүгийн эрсдэлд орж байгаа юм бий.

Тэгэхээр миний асуух гээд байгаа 2 юм бол 1 дүгээрт нь, 2024 оны төсөвт тооцож байгаагаар ямар хэмжээний орлого төвлөрнө гэж үзэж байгаа вэ?

2 дугаарт нь, нэг тодорхой багцаагаар ямар хэмжээний иргэн энд хамрагдаж болохоор ер нь тооцож байна вэ? Хэдэн иргэн оролцож, юу гэж тооцож байна вэ?

3 дахь нь юм нь энэ сангаар нөгөө Монголд эмчилдэг болгох, Монголд эмчилдэггүй өвчнүүдээ эмчилдэг болгох, түүний тоног төхөөрөмжийг, боловсон хүчнийг бэлдэх чиглэлээр энэ сангийн зориулалт байх уу гэсэн ийм 3 зүйлийг тодруулъя.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайд хариулах уу? Чинзориг сайд.

С.Чинзориг: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Одоо бид энэ тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулснаар шинээр тусгай сан байгуулах гэж байгаа асуудал биш. Одоо бол энэ тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих сан гэж байгаа. Энэ сангийн орлогыг архи, тамхины онцгой татварын 1-2 хувь, эмийн гаалийн болоод нэмэгдсэн өртгийн 2 хувийн орлогоор бүрдүүлж байгаа. Яг ингээд энэ одоо байгаа энэ эрүүл мэндийг дэмжих сангийнхаа хамрах хүрээг нь бас жаахан өргөжүүлж л өгч байгаа юм. Шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө хариуцаж энэ шинэ технологи нэвтрүүлж гэхээр ийм зардал санхүүгийн боломж гардаггүй. Тийм учраас шинэ технологи нэвтрүүлэх зардлыг энэ сангаас шийдэж өгье. Тэгээд дараа нь энэ шинэ технологи Монголд нутагшлаа гээд мэргэжлийн салбар зөвлөл нь дүгнэлт гаргасан нөхцөлд цаашид нь дараагийн шат буюу нөгөө Эрүүл мэндийн даатгалын сангаасаа санхүүжилт аваад яваад байдаг тэр боломжийг нээж өгөх гэж байгаа юм.

2 дахь асуудал нь энэ гадаадад зайлиггүй шаардлагаар гадаад улс орнуудад эмчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд нэг гадагшаа яваад ирсэн хойно нь зардал төлбөрийнх нь тавхан хувийг өгдөг. Энэ дэндүү бас бага байна гэж. Тийм учраас энэ гадаадад зайлиггүй шаардлагаар эмчилгээнд хамрагдаад ирсэн иргэдэд олгож байгаа энэ зардлынх нь хэмжээг тодорхой үе шаттайгаар

нэмэгдүүлж. Боломж бол бид нар нэг хүүхдийн эмчилгээний зардлыг нэг 50 хувийг нь буцааж олгодог байх, том хүний эмчилгээний зардлыг 20 хувийг нь олгодог байя гэсэн ийм төсөл боловсруулж бид урьдчилж төсөөлж тооцоо хийж байгаа. Ингээд энэ хуулиараа энэ эрүүл мэндийн дэмжих сангийн журмыг Засгийн газар баталдаг. Тийм учраас Засгийн газар энэ журмыг хууль батлагдвал батлах юм.

Би түрүүн хэлсэн. Ер нь сүүлийн жилүүдэд нэг хуулиараа тэр 3 архи, тамхи, эмийн татваруудыг ингээд гүйцэтгэлээр нь аваад үзвэл нэг жилд 10-12 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна. Төвлөрөхөөр байгаа юм байна лээ. Гэтэл ерөөсөө жилийн жилд нэг улсын төсөв дээр нэг 2-3 тэрбум төгрөг л тусгаж өгдөг. 2023 оны улсын төсөв дээр энэ эрүүл мэндийг дэмжих санд 2 тэрбум төгрөг зарцуулахаар л төсөв баталж өгсөн.

Харин 24 оны улсын төсөв дээр тусгай сангийн тухай хуульд зориулалт нь бас өөрчлөгдөж, хамрах хүрээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх хөрөнгийг 5 дахин нэмэгдүүлж, 10 тэрбум төгрөгийг Эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэхээр улсын төсөв дээр тусгаж байгаа. Тэгэхээр энэ 10 тэрбум төгрөгтөө багтааж бид нар бас үйл ажиллагаа явуулах ийм асуудлууд бий.

Төгсгөлд нь нэг зүйл хэлэх дээр шаардлагатай байгаа оношилгоо, шинжилгээний тоног төхөөрөмж худалдаж авах асуудал, дээр нь энэ шинэ технологи нутагшуулахтай холбоотойгоор эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, багаар нь бас чадавхжуулах ийм бас арга хэмжээ энэ хүрээнд авна. Ер нь зүгээр 22 онд аваад үзэхэд нэг 400 орчим хүн 13 тэрбум төгрөгийн гадаад эмчилгээний зардал гарсан гэсэн ийм нэхэмжлэл манайд ирүүлсэн байдаг. Үүний 5 хувь гэвэл 600

орчим сая төгрөгийг нь энэ Эрүүл мэндийг дэмжих сангаас нэмэгдүүлж өгсөн, нөхөн бас төлж өгсөн байдаг ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр ийм учраас бид нар хүүхдийг жаахан ялгавартайгаар жаахан арай зардлыг нь арай том 50 хувь болгож нэмэгдүүлье, том хүний зардлыг нь 4 дахин нэмэгдүүлээд 20 хувийг нь буцаан өгдөг, нөхөж өгдөг байх нь зүйтэй гэсэн ийм чиглэлээр энэ хуулийн төслийг боловсруулсан.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Чинзориг сайдад. Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ Монгол Улсын иргэдийн дунд ялангуяа хүүхдүүдийн дунд энэ чихрийн шижин өвчин, сахрын хэрэглээ хэт их өндөр байгаа. Энэтэй уялдуулаад ер нь манай эрүүл мэндийн салбарын бас гол шийдэх асуудлуудын нэгэнд яах аргагүй энд онцгой анхаарал хандуулахаар энэ бүх хөтөлбөрүүдэд орсон байгаа. Үүний дагуу бид хэсэг гишүүд хэт их өндөр чихрийн агууламжтай ундаанд онцгой татвар ноогдуулахаар ийм хуулийн төсөл өргөн барьсан. Энэ чиглэлээр хэлэлцүүлэг хийхэд бүгд энэ мэргэжилтнүүд дэмжиж байгаа юм. Тэгэхээр Чинзориг сайд аа, энэ эрүүл мэндийг дэмжих сангийнх чинь зөвхөн архи, тамхи, эм байгаа шүү дээ. Тэгэхээр тэр хууль өргөн баригдаад батлагдсаны дараа дагалдах хууль гээд тэндээс орж ирж байгаа онцгой татвар чинь татварын өсгөх зорилготой биш байхгүй юу. Эрүүл мэндийг дэмжих зорилго. Тэгэхээр энэ дээрээ нэмэлтээр тэр татварыг ийшээ оруулахаар дагалдах хуулиа санаачлаад оруулчхаж болно биз дээ, хамт өргөн бариад.

Г.Тэмүүлэн: Чинзориг сайд Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайдын микрофоныг.

С.Чинзориг: Яах вэ, Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь нийт иргэдийн дунд энэ чихрийн шижингийн өвчлөл нэлээн бас өндөр байгаа. Түүн дотроо энэ хүүхдийн бас сахрын өвчлөл өндөр байна гэх ийм асуудлууд бий. Бид энэ, ер нь чихэрлэг бүтээгдэхүүнийг онцгой татвартай болгохгүй гэдэг асуудлыг энэ хуулийн төслийг боловсруулах явцад нэлээн судалж үзсэн. Нэг хэсэг нь чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн гэдгээрээ явах ёстой гэдэг. Нэг хэсэг нь чихэрлэг сахарын агууламж өндөртэй ундаа гэж оруулах нь зүйтэй гээд нэлээн ярьдаг юм байна лээ. Би ер нь энэ хуулийн төсөл цаашидаа ер нь оруулбал чихэрлэг зөвхөн ундаа гэхгүйгээр хүнсний бүтээгдэхүүн гэдгээр нь оруулбал яасан юм гэсэн ийм бодолтой байдаг. Гэхдээ энэ удаа ингээд Засгийн газар аливаа татвар бас нэмэгдүүлэхгүй байх ийм бас бодлого баримталж байгаа учраас би энэ хуулийн төслийг боловсруулахдаа орлого тал дээр нь өөрчлөлт оруулах, ялангуяа тэр чихэр бүтээгдэхүүнээс онцгой татвар авах асуудлын хуулийн төслийг санаачилж оруулаагүй. Гишүүдийн өргөн барьсан тэр хуулийн төслийн хэлэлцүүлэг намар болсон байна лээ, манай яамны бас холбогдох газрын дарга нар оролцсон. Тэр хуулийн төсөл орж ирээд бас хэлэлцүүлэгдээд явах юм бол бас дэмжээд ажиллах тийм бас боломж байгаа.

Хэрвээ тэр Их Хурлын гишүүдийн тэр хуулийн төсөл өргөн баригдаад ороод ирвэл бас хамтатгаад хэлэлцүүлээд явах асуудал ч бас байхыг боломж гарах болов уу гэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: 2, 3 зүйл байна.

1 дүгээрт, энэ Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэр жилд ер нь хэдий хэмжээний юм ордог юм гэдэг

асуудал байна. Өнөөдөр энэ сангийн үлдэгдэл гэж ер нь юм байна уу гэдэг асуудал байгаад байна.

3 дахь зүйл энэ дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаад байгаа өвчнүүдийг оноилох, эмчлэх, техник технологи нэвтрүүлэх, боловсон хүчнээ бэлтгэх энэ ажлыг эндээс гаргаж болох юм, 1.

2 дугаарт, ерөөсөө энэ чиглэлээр нь дагнаад бэлтгэгдчихсэн гаднын чадварлаг багийг оруулж ирж, хамтарсан судалгаа үйл ажиллагаа явуулах чиглэл дээр бид илүү анхаармаар санагдаад байгаа юм. Энэ асуудал энэ дотроо яг оров уу, яаж тусаж байна вэ гэж. Ер нь гадагшаа явж хүнээ эмчлүүлнэ гэдэг бол үндсэндээ эмчилгээний зардлаас гадна тийз, виз, тэгээд тэр дагаж очсон улсуудын амьдрах орчин энэ тэр гээд зардлыг асар өндөрлүүлж байгаа байхгүй юу. Тийм учраас харин гаднаас тийм багуудыг урьж авчирч эндээ хийж чаддаг байж чадах юм бол энэ шууд гарах зардлуудыг илүүтэй бууруулах, энэ өвчин эмгэгтэй байгаад байгаа улсууддаа бас нэлээн дэм болж чадах ийм л зүйл байгаад байгаа. Би бол энэ урсгалыг нь илүү дэмжвэл болох ёстой юу, энэ талаар ер нь наад хуулийн чинь өөрчлөлтөд ямар үг үсэг орчхов гэдэг асуудал байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Чинзориг сайд.

С.Чинзориг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Түрүүн би хэлсэн, одоо энэ тусгай сангийн тухай хуулийн дагуу байгуулагдсан Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэр бол 3 эх үүсвэр л байгаа юм. Архи, тамхины онцгой татвар, тэгээд эмийн, гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварын 2 хувиар бүрдэнэ гээд. Яг үүний гүйцэтгэлээр нь ингээд тооцоод үзвэл нэг жилд нэг энэ санд нэг 10-12 тэрбум төгрөг төвлөрөхөөр ийм тооцоо байдаг

юм. Тэгээд сүүлийн нэг 4-5 жилийн энэ санд төвлөрүүлсэн хөрөнгийг харахаар нэг жилд 1 ерөөсөө 2-оос гуравхан тэрбум төгрөг л, өөрөөр хэлбэл нийт орлогынх нь төвлөрөх ёстой орлогынх нь 30 хувийг л өгч байсан юм байна лээ. Энэ жил ч гэсэн 2023 онд улсын төсөв дээр ч гэсэн ирэх Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөд төсөвт нэг 2 тэрбум төгрөг л туссан юм. Одоогийн байдлаар 50 хувийн гүйцэтгэлтэй байгаа юм байна лээ. Ийм явцтай байна.

2 дахь асуудал нь тэр одоо бидний оруулж ирж байгаа энэ төсөл зөвхөн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гээд тэр нэг сургалт, судалгаа, тандалт судалгаа нөлөөллийн ажил хийдэг нь бас жаахан явцуу байна гээд энэ шинэ технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг л оруулчихсан юм. Энэ дотор таны хэлээд байгаа 2 чиглэлийн чадавх бэхжүүлэх юмыг би хийх ёстой гэж бодоод байгаа юм.

Нэг дэх чиглэлийн асуудал нь өөрсдийнхөө энэ шинэ технологи нутагшуулахтай холбоотойгоор үндэсний багийг гадаад улс орнуудад бас сургах чадавхжуулах асуудал.

Нөгөө талаасаа таны хэлээд байгаа гадаад орноос өндөр чадвартай баг бас авчирч дотоодынхоо мэргэжилтнүүдийг дагалдуулах замаар чадавх бэхжүүлэх гэсэн ийм 2 чиглэлийн 2 орох гарах ийм чиглэлийн, урсгалтай ийм чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг авах нь зүйтэй. Ингэж чадах юм бол бидний энэ гадагшаа эмчилгээнд явж байгаа иргэдийн энэ урсгал бас буурах, иргэдэд ирж байгаа энэ төсөв санхүүгийн дарамт бас буурах ийм асуудлууд гарна гэж. Одоо бол манайд 17 онд Эрүүл мэндийн сайдын тушаал гараад дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа 26 нэр төрлийн өвчин байна гэсэн ийм судалгаа гарсан юм байна лээ. Одоогийн байдлаар манайх нэг 3-ыг нь Монголд нутагшуулчихаад байгаа гэж үздэг. Ингээд энэ жагсаалтыг

шинэчилбэл нэг 23 орчим өвчний төрөл өвчнийг бид дотооддоо оношилж эмчилж чадахгүй байна гэсэн ийм асуудал байгаа. Энэ 26 өвчний 14 нь хүүхдийн өвчин байгаа юм байна лээ. Хүүхдийн. Тийм учраас тэр хүүхдэд олох зардлыг нь бас жаахан ахиулан 50 хувиар ч юм уу хөнгөлдөг болговол яасан юм бэ гэсэн ийм асуудлууд байгаа юм.

Би бол тэр гадагшаа явж байгаа иргэдэд эмчилгээний зардлыг өгнө гэхээсээ илүүтэйгээр тэр технологи нутагшуулах, чадавх бэхжүүлэх тэр ажилд нэлээн илүү анхааръя. Сангийн хөрөнгийн нэг 50-аас доошгүй хувийг нь тэр чиглэл рүү зарцуулах ёстой гэсэн ийм бодолтой байгаа. Ингээд Засгийн газар эрүүл мэндийг дэмжих сангийн журмыг нь батлах юм, хуулиараа. Тэгээд энэ Засгийн газраар батлуулахдаа үүнийг нь бас нэлээн тийм бодож үзнэ ээ гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж, дууслаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд санал хураалтыг явуулж эхэлье.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжин, 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа гишүүн та

танилцуулах уу? Тэгье. Одонтуяа гишүүн танилцуулъя.

Ингээд хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

18.18 цаг

Ингээд дараагийн хэлэлцэх 3 асуудалтай холбогдуулж ажлын хэсгийн санал, дүгнэлтүүд эцэслэн орж ирээгүй байгаа учраас Байнгын хорооны хуралдааныг түр хугацаагаар хойшлуулж байна. Түр завсарлуулж байна.

ЗАВСАРЛАГА

5 дахь асуудал. Монгол Улсын 2024 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд байгаа.

6-д нь, нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл байгаа.

7-д нь, Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүд байгаа.

Энэ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Тогтохсүрэн дарга горимын санал байгаа юу? Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: 2024 оны төсөв дээр бас хэвлэлтэд бэлтгэж байгаа гээд жаахан цаг авах юм байна. Тийм учраас би гаргах гэж байгаа горимын санал. Хэлэлцэх асуудлын 7 дугаарт байгаа 2024 оны төсвийн тухай хуулийг дагаж өргөн барьсан хууль, тогтоолын төслүүдийнхээ эцсийн хэлэлцүүлгийг хийчихье.

Өдөр ажлын хэсэг хуралдаад эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэчихсэн байгаа. Үүнийг хэлэлцээд явчихъя гэдэг

ийм горимын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье. Байнгын хорооны гишүүдэд.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүний горимын саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад 9 гишүүн оролцож, 75 хувиар дэмжигдлээ.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Нэгдсэн хуралдаанаар нийт 21 хууль, Монгол Улсын Их Хурлын 7 тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналыг хууль, тогтоолын төслүүдэд нэмж тусган, төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хувилбарыг та бүхэнд бэлтгэн тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Юуны өмнө. Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн бас танилцуулах мэдээллийг хийх юм байна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх 1 зарчмын зөрөөтэй санал, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тул Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх 1 зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг бэлтгэсэн болно.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Эцсийн хувилбарын төслүүдтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Раднаасэдийн гаргасан зарчмын зөрөөтэй саналаар санал хураан дэмжигдсэн боловч уг саналаар дахин санал хураалгах шаардлагатай талаар хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу ажлын хэсгээс зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлдсэн байгаа.

Тогтохсүрэн гишүүн үүнийг танилцуулах юм байна. Тэгээд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ саналаар санал хураалт явуулна.

Тогтохсүрэн гишүүнд микрофон өгье.

Д.Тогтохсүрэн: Энэ тэр шүүх, энэ 2-ын юуны төслийн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр зарчмын зөрөөтэй саналыг Раднаасэд гишүүн өнгөрсөн Байнгын хорооны хуралдаанд гаргасан. Тэр санал Байнгын хорооны хурал дээр унасан. Нэгдсэн чуулган дээр боссон юм. Тэгээд үүнийг дахиж хэлэлцэх шаардлагатай гэж ажлын хэсгээс үзсэн. Үзэж байгаа үндсэн шалтгаан нь юу байна вэ гэхээр Улсын Их Хурал бол энэ нөгөө газрын агентлагийн чиг үүрэг байгаа, заалт нь. Газрын агентлагийн чиг үүрэг буюу 23.2.23 дээр газрын агентлагт өгч байгаа чиг үүрэг дотор анхны нөгөө төсөл нь төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга объектыг төрийн өмчид хураан авах ажлаа зохион байгуулна гэсэн ийм санал байгаа. Тэгээд энэ саналаар нь явах ёстой юм байна. Өглөө бид нар ажлын хэсэг дээр ярьж байгаад жаахан өөр болгосон юм. Тэр өөр болгосон хэлбэрийг дэгийн хууль зөрчинө гэж үзэж байгаа юм байна.

Тэгэхээр одоо би юу гэх гэж байна гэхээр 23.2.23 дугаар заалтыг дахиж оруулж байгаа. Тэгээд үүнийг дахиж оруулж байгааг нь 23.2.23 дахь заалтыг хасах саналаар оруулж байгаа гэсэн үг. Тэгээд үүнийг 3-ны 2-оор бид нар

шийдвэрлэх ёстой. Тийм учраас Байнгын хорооны гишүүд маань энэ дээр анхааралтай хандана биз. Гол нь бид нар ингээд байгаа юм. Парламент бол төрийн юу, мэдээж энэ төрийн өмчит компаниудын газар дээр хууль бусаар баригдчихсан газрууд байгаа юм. Тэрийг үгүйсгэхгүй. Гэхдээ тэрийг ганцхан шүүхийн шийдвэрээр л хураах ёстой. Түүнээс биш парламент шийдвэр гаргаж хурааж авч огт болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ заалтыг ямар нэгэн хэлбэрээр дэмжмээргүй байгаа юм.

Тэгээд өнгөрсөн чуулган дээр босчихсон юм. Тэгээд ажлын хэсэг дээр ярилцаж байгаад та нарт тараагдсан тэр томъёолол буруу томъёолол нь шүү. Яг Раднаасэд гишүүний өөрийнх нь томъёолол 23.2.23 төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга, объектыг төрийн өмчид хураан авах ажлыг зохион байгуулна гэсэн. Яг ийм томъёоллоор байгаа шүү. Энэ томъёоллоор гэж та бүхнийг ойлгоорой гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Тэрийг нь бид нар ингэчихсэн юм. Бид нар ийм хэлбэрээр шүүхийн шийдвэр гарчихсан бол болно гэдэг хэлбэрээр явсан чинь үүнийг манай Тамгын газрынхан юу гэсэн гэхээр ингэж өөрөөр хэлбэл Их Хурлын чуулган дээр босчихсон саналыг ажлын хэсэг ингэж засаж болохгүй ээ. Зөвхөн Байнгын хороо гуравны хоёроороо үүнийг хасах санал хурааж хасаж болно. Өөр та нарт ямар ч эрх байхгүй ээ гэсэн юм. Тийм учраас би яг Раднаасэд гишүүний үндсэн санал одоо хураагдана. Тэрийг та бүхэн хасах саналыг дэмжиж өгөөч ээ л гэж хэлэх гэж байгаа юм. 3-ны 2-оор.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ чинь ямар чөтгөр нь очоод юу гээд ярьчихсан юм бэ? Үгүй ээ, тэгээд өдөр ярихдаа энэ чинь шүүхийн шийдвэрээр гэдгээр ингээд

зохион байгуулна гээд ингээд явчихъя гээд тохирсон шүү дээ, уул нь. Тэгээд одоо болохоор хасъя гээд байх юм. Одоо энэ сургууль, цэцэрлэг, эмнэлгүүд яг бодит үнэн, бүгд дээр нь л шийдвэр гарчихсан байгаа шүү дээ. Үгүй ээ, үгүй, үгүй энэ би энэ шүүхийн шийдвэрээр гэдэг үгийг чинь дэмжиж байгаа шүү дээ. Минийх угаасаа хууль зөрчсөн болох нь тогтоогдсон бол гэж үг байгаа. Энэ байна шүү дээ. Энэ зохион байгуулах ажлыг энэ агентлаг л хийхгүй бол тэр дүүрэг, сум, аймгийн, дүүрэг, сумын газрын албаныхан хийж чадахгүй ээ. Одоо энэ 1 дүгээр эмнэлгийн хашаанд баригдаж байгаа 16 давхар барилгыг чинь хотын Засаг дарга чинь зогсооно гэж байна шүү дээ. Өөр тэр хүнд тэрнээс өөр юу байхгүй байхгүй юу. Эрх зүйн боломж. Зогсоохоос өөр. Хариуцлага хүлээлгэе гэхээр ямар ч хариуцлага байхгүй.

Хэрвээ үүнийг нь ингээд тодорхой энэ чинь нохойтой гээд айлын хашааны үүдэн дээр нохойтой гээд биччихсэн тэр хүн болгоомжтой хандана биз дээ. Яг түүнтэй чинь ижилхэн би тэр барилга барьж байгаа хүнийг чинь хамгаалах гээд байгаа юм. Энэ хуулийг зүгээр буцаан хэрэглэхгүй ээ ч гэдэг юм уу тийм ийм зохицуулалт байж болно. Энэ чинь өнөөдрөөр юм зогсохгүй шүү дээ. Маргааш, нөгөөдөр энэ, одоо энэ Улаанбаатар хотын нөхцөл байдал чинь аймгуудад шилжинэ. Дараа нь сумдад шилжинэ. Энэ хасна гэж ерөөсөө ийм юм. Чиглэл авна гэдэг чинь дахиж янзалъя л гэсэн юм болохоос хасна гэж чиглэл аваагүй биз дээ.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн дарга хариулт өгье.

Д.Тогтохсүрэн: Энэ ийм байна, Раднаасэд гишүүн ээ. 1 дүгээрт, яг хурал даргалагч энэ заалтыг дахиж авч үзэж шийд гэдэг ийм дахиж авч үз гэдэг ийм чиглэл өгөөгүй юм байна. Чиглэл өгөөгүй учраас бид нар тэр шүүхийн шийдвэр гэж бичих ямар ч боломжгүй юм байгаа юм. Дэгийн хуулиараа. Ганихан ажлын

хэсгээс ямар санал гаргах вэ гэхээр энэ саналыг 3-ны 2-оор хасах саналыг дэмжиж өгөөч ээ гэдэг тийм санал гаргах эрх дэгийн хуульд бид нарт үлдэж байгаа юм.

Нөгөө талаас нь би ярья. Нөгөө талаас нь ийм байгаа юм, Раднаа дарга аа. Одоо байгаа газрын тухай, газрыг хэн олгодог вэ гэхээр газрыг олгодог субъект нь Засаг дарга байгаа. Бүх шатын Засаг дарга, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга газар олгоно. Энэ манай хуульд байж байгаа зүйл. Газар олгодог субъект, газар олгодог субъект хууль бус газрыг хураан авах, төрийн өмчийн газар дээр байгаа өмчийг төрийн өмчийн газар дээр хууль бусаар баригдсан барилгыг хураан авах энэ бүх ажил бол тэр Газрын тухай хуулиараа Засаг даргын чиг үүрэг дээр байгаа юм. Тэгээд яагаад тэр дээр байгаа юм гэхээр тэр өөрөө нөгөө газар олгодог, хүчингүй болгодог субъект нь байхгүй юу.

Одоо энэ газрын агентлаг дээр ингээд орчихоор энэ газрын агентлагт бол газар хураадаг, газар олгодог, хүчингүй болгодог ийм эрх газрын агентлагт байхгүй байхгүй юу. Тийм. Тэгэхээр газрын агентлагт ийм чиг үүрэг өгч байгаа нь хууль бус болоод байна л гэж үзэж байгаа юм. Ер нь бид нар Раднаа гишүүний яриад байгааг ойлгож байгаа юм. Олон төрийн өмч дээр байгаа газрууд хууль бус олгогдоод, тэр нь ингээд байшин барилга болоод, зарагдаад ингээд явчихдаг гэж. Энэ дээр бид нар хамгийн түрүүнд 1 дүгээрт тэр газар олгодог субьекттэйгээ хариуцлага хүлээхтэй холбоотой асуудлыг л уул нь болдог энэ хуульдаа оруулж өгмөөр байгаа юм. Тэгэхгүйгээр бид нар парламент хурааж авахтай холбоотой асуудлаар шийдвэр гаргаж арай болохгүй болчихоод байгаа юм.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн нэмж тодруулъя.

Ш.Раднаасэд: Тэгвэл би өөрөө энэ саналаа татаж аваад, яг энэ байдлаар чинь засаад оруулчихъя л даа. Өөрийнхөө гаргасан саналыг татаж аваад, яг энэ байдлаар чинь засаад оруулчихъя. Энэ хавдрын дарга энд ирчихсэн байна. Эрдэнэхүү дарга аа, танайх хэрвээ 300 ортой эмнэлгээ 600 болгоход хэрвээ бусдад газраа алдаагүй бол нийт газрын чинь хэмжээ хэд байсан, одоо хэдийг нь алдчихаад байгаа юм. Тийм барилгажих боломж бололцоо байсан уу, байгаа юу? Жишээлэх юм бол. Зүгээр энгийн жишээ эндээс л хэдүүлээ ярьчихъя л даа. Эргэн тойронд нь машин, хүн явах багтах зай байхгүй, эмнэлэг дотор нь ороод хөл тавих зай байхгүй. Тэр тэгээд л өмнөхөөрөө л үлдэнэ шүү дээ, энэнээс.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн та тэгэхээр. Раднаасэд гишүүн та тэгэхээр нөгөө гаргасан саналаа татаж авъя. Тэгээд зарчмын зөрөөтэй саналын томъёолол өөрөө дахиад Байнгын хороонд оруульа гэсэн санал гаргаж байна тийм ээ. Тэгэхээр Раднаасэд гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналыг татаж авах нь байна. Татаж авч байна. Тэгээд та зарчмын зөрөөтэй саналаа дахиад өөрөө гаргаад санал хураалгах нь байна шүү. Та тэгвэл татаж авч байгаагаа хэлчих үү, микрофон дээр. Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ ч 3-ны 2-оор чинь явахгүй л дээ, тийм ээ. Ер нь яах вэ, энэ Эрдэнэхүү даргын юмыг, үндэслэлийг бас та бүхэн сонсоорой. Энэ яагаад үүнийг бид нар хийх ёстой юм гэж. Яах вэ, энд хэн нэгний эрх ашгийг өнөөдөр баригдсан байгаа барилгуудыг нь нурааж биш. Энэ хурааж авахдаа нэг их асуудал биш байгаа юм. Хожмын өдрүүдэд тэрийг бусад хүмүүст их том болгоомжлол үүсгэж л энэ хамгаалах гээд байгаа юм л даа, газраа, төрийн. Энэ өмнөх саналаа би Тогтохсүрэн дарга аа, олонхын бүлгийн даргын баталгаа гаргалаа гэж ойлголоо шүү. Та саналаа өөрчлөөд ороод ирвэл би дэмжинэ ээ, бид дэмжье ээ гэж байна. Зөв үү?

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн та яг тодорхой санал гарга. Раднаасэд гишүүн ээ, та гаргасан саналаа татах уу. Эсвэл 3-ны 2-оор санал хураалт явах процесс үүсгэх гээд байна.

Ш.Раднаасэд: Тэгвэл 23.2 дээр би 23 дугаар зүйл дээр 2 дахь бас нэг санал хураалгая. Яг үнэн. Саяынх яг зөв хувилбар байна. Тэр санал нь болохоор яах вэ, өмнөх саналаасаа ялгаатай нь болохоор шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол гэж. Тэр агуулгаар энэ саналын томъёоллыг Тэмүүлэн даргад өгчихье.

Г.Тэмүүлэн: Тэгвэл саналын томъёоллоо шуурхайтай бичээд наашаа гаргаад өг. Тэгээд санал хураалгая. Эхлээд саналаа татаж байна гэсэн үг шүү дээ, дэгээрээ. Тэгэхээр 2 санал болохгүй. Эхлээд татаж байж дараагийнхаа гаргасан саналаа гаргана гэсэн үг.

Томъёоллоо гялалзаарай, томъёоллоо бичээд өгөөрэй. Тэгээд та саналаа татаж байж наад саналаар чинь санал хураалт явуулна. Тэгээд та саналаа татаж байна гэсэн үг шүү. Өмнөх санал дээр.

Раднаасэд гишүүний микрофоныг өгье.

Ш.Раднаасэд: Төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.24 дэх заалтыг нэмэх:

23.2.24. төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах гэж.

Г.Тэмүүлэн: Сая энэ уншсан томъёоллоор та саналаа гаргаад, өмнөх саналаа татаж байна гэж ойлголоо шүү. Тэгвэл 23.2.23-аар бид нар эхлээд 3-ны 2-оор санал хураалт явуулна. Тэгээд

сая 23.2-ын таны гаргаж байгаа 24 дээр чинь дахиад санал хураалгах нь байна шүү дээ. Ингээд дэгээрээ явъя.

Раднаасэд гишүүн. 23.2.24-ийг та санал хураалгахын тулд 23.2.23-аа эхлээд татна гэсэн үг. Тэгж байж санал хураалгана. Дэгийн зөрчил үүснэ, энэ дээр яг.

Микрофон дээр та дахиад хэлчих. Татлаа гэж ойлголоо шүү. Албан ёсоор протоколд. Микрофонд заавал ч үгүй та хэл. Саналаа татаж байна гэдэг дээр.

Үгүй бол бид нар 3-ны 2-оор сая явах болчихож байгаа.

Ш.Раднаасэд: Яах вэ дээ, тэгээд өөрсдөө л мэд. Унагаавал унагаагаад, босговол босгоно биз. Би ямар ч байсан саналаа хэлсэн. Энэ санал нь уул нь дэгээрээ үүнийг чиглэл авъя гэж хэлж чиглэлийг нь би авчихсан гэж ойлгосон байхгүй юу. Ер нь үүнээс хойш Тогтохсүрэн дарга аа, чуулган дээр санал хураагаад дууссаны дараа ингээд энэ дээр чиглэл авъя гэж араас нь ярьдаг бас буруу байхгүй юу. Түүнээс чинь болоод дэмжигдсэн санал дахиж яригдах дээрээ тулж байна шүү дээ. Гэхдээ тэгээд, тийм, шүүхийн шийдвэртэй гэдгээр нь оруулж л байна л даа. Саналаа татаж авъя, авъя.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Баярлалаа. Ингээд Раднаасэд гишүүн гаргасан саналаа татлаа.

Ингээд 23.2.23 дээр зарчмын зөрөөтэй саналын томъёолол Раднаасэд гишүүн гаргаж байна, нэмж. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар баригдсан нь талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах гэдэг саналын томъёолол гаргаж байна, тийм ээ. Томъёолол нь зөв биз.

Дахиад уншъя. Төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад

байгаа газар дээр хууль бусаар баригдсан барилга байгууламжийн талаар тийм ээ, Раднаасэд гишүүн. Томъёолол нь тийм байна, талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах гэдэг зарчмын зөрөөтэй саналын томъёолол гаргаж байна.

Тогтохсүрэн гишүүн горимын санал гаргах нь байна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр нөгөө дэгийн хуулиараа л бид нар яриад байгаа юм шүү. Раднаа гишүүн 1 дүгээрт нь, татах санал байхгүй юм байна, татах боломжгүй юм байна. Тэгээд би ажлын хэсгээс ийм санал оруулах гээд байна л даа. Раднаа гишүүний гаргасан саналыг чуулган дээр дэмжигдсэн. Тэгээд тэр саналыг ингэж засаж оруулж байгаа юм. Тэгээд үүнийг 3-ны 2-оор дэмжвэл явах гээд байгаа юм. Тэр нь юу гэсэн санал вэ гэхээр та нарт тарааж өгсөн 2.23. төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах гэж. Яах вэ, түрүүнд нь байгаагаас ялгаатай нь тэр дээр нь баригдсан объект заавал хууль бус шүү гэдгийг нь шүүх шийдвэр гаргасан байж байх ёстой. Тэр нь хүчин төгөлдөр гэдэг чинь 2 шатын шүүхээр, тийм, тийм, тийм. Гэхдээ тэр нь хуулийн хүчин төгөлдөр гэдэг чинь 2 шатын шүүх л байх ёстой шүү дээ. Тийм, бүх шатын шүүхээр гарсан байх ёстой байхгүй юу. Тэгэхээр тэр нөгөө хамгийн гол юм энэ хөрөнгийг хураа гэдэг шийдвэр гарсан байх ёстой л гэж байгаа байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Одонтуяа гишүүн. Та горимын санал гаргах юм уу?

С.Одонтуяа: Үгүй ээ, тэгэхээр ийм байхгүй юу даа. Бид нар одоо Монгол Улсад мөрдөгдөж байгаа хуулийг дагаж

мөрдөх ёстой шүү дээ. Угаасаа аль нэг барилга байгууламжийг хураавал шүүхийн эцсийн шийдвэр гарч байж л хураадаг. Тэрийг хураах ажиллагааг зохион байгуулдаг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба гээд байгууллага байна. Энэ агентлаг яагаад тэр шүүхийн шийдвэр гүйцэтгэх албын ажлыг барьж авч очиж сүржигнэж тэр агентлаг тийм юм руу орох гээд байгаа юм. Үгүй ээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бол шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд биелүүлэх үүрэгтэй байгууллага мөн биз дээ. Тэгэхээр одоо 3-ны 2-оор Раднаасэд гишүүний саналыг унагаагаад л бол оо. Дахиж санал гаргах хэрэггүй. Энэ шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд гэж яагаад давхар бичих гээд байгаа юм. Угаасаа Монгол Улсад шүүхийн шийдвэр гараагүй тохиолдолд юмыг хураах эрхгүй шүү дээ. Хэн ч эрхгүй шүү дээ. Тэгээд ийм давхар давхар юм хийх гээд байх юм, хэрэггүй байхгүй юу. Тийм, тийм, тэгэхээр зүгээр 3-ны 2-оор энэ буруу саналыг унагаах нь зөв. Яагаад гэхээр нэг жишиг тогтох гээд байна шүү дээ. Ингээд нэг агентлаг нь хурааж болдог. Тэгэхээр үүнийгээ унагаагаад л бол оо. Бусад бүх ажлыг хийдэг хууль Монгол Улсад байгаа байхгүй юу. Хүний өмчийг шүүхийн шийдвэргүй хураахгүй ээ. Шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гэж байгууллага нь энэ ажлыг хэрэгжүүлнэ ээ. Тийм байхгүй юу. Одоо тэгээд л 3-ны 2-оор унагаагаад л бол оо.

Г.Тэмүүлэн: Ок. Ойлголоо. Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүн гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэж үзсэн гэж байгаа юм байна. Тэгэхээр энэ томьёоллын дагуу энэ Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хураах нь ээ.

Ингээд санал хураах нь байна. Тэгээд би 23.2.23-ыг нь дахин хураалгах шаардлагатай гэсэн саналыг уншъя. Санал нь энэ байна тийм ээ. Тэгээд 23 дугаар зүйлийн 23.2.23-ыг дахин хураах шаардлагатай гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулах нь байна. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалтын дүнг танилцуулъя. 57,1 хувиар саяын санал дэмжигдсэн. Ингээд 3-ны 2-оос доошгүйн саналыг авч чадаагүй тул дэмжигдсэнгүй гэж ойлгож байна.

Сандагаа гишүүн та санал гаргая. Таны микрофон ажиллаагүй, төхөөрөмж ажилласангүй гэж үү. Сандагаа гишүүн санал гаргая.

Ц.Сандаг-Очир: Би Байнгын хорооны дарга аа, би сая уг нь дэмжсэн юм. Гэтэл миний санал эсрэг гарсан байна. Төхөөрөмж дээр алдаа гарсан байна. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахиж санал хурааж өгөөч.

Г.Тэмүүлэн: Төхөөрөмж ажиллаагүй тул саяын явуулсан санал хураалтыг дахин явуулъя гэсэн саналаар хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг Сандаг-Очир гишүүний саналаар явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай.

85,7 хувиар дэмжигдсэн тул ингээд түрүүний санал хураалтыг дахин явуулъя. 3-ны 2-оор. Одоо түрүүний санал хураалтыг дахин явуулна. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзвэл гэсэн байгаа. Ингээд үүнийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

14 гишүүн хуралдаанд оролцож, 14 гишүүн дэмжин, 100 хувиар дэмжигдлээ.

Одоо томъёоллыг нь уншъя. Томъёолол нь төслийн 2 дугаар зүйлийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.23 дахь заалт нэмэх: 23.2.23 төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшил ашиглалтад байгаа газар дээр хууль бусаар барилга байгууламж баригдсан талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хураан авах ажлыг зохион байгуулах гэсэн ийм томъёоллоор байгаа юм байна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал 92,3 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт. Дараагийнх нь санал байна. Дараагийнх нь “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 4 дүгээр заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу ажлын хэсгээс зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлтгэн ирүүлсэн байна. Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалтыг явуулна. Та бүхэнд уншиж танилцуулъя.

Төслийн 4 дэх заалтыг 2 дахь заалт болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах: 2. дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар Л.Оюун-Эрдэнэ, Монголбанк Б.Лхагвасүрэнд тус тус даалгасугай.

1. Орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулагч хөтөлбөртэй уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах,

2. Агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй нийт талбай нь 100м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах. Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явж байна.

100 хувиар дэмжигдлээ, санал хураалт.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

20.36 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд. 2 дугаар хэлэлцүүлэг байгаа. 2 дугаар хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Танилцуулгыг ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга танилцуулна. Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний ... Энэ нөгөө дээд талын толгойг нь солиод биччихсэн байх юм. Толгойг нь солиод биччихсэн байх юм, манай хүмүүс хаана

байна. Энэ 2 хуулиа холиод бичсэн. Тийм байна.

2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурал 1 дүгээр хэлэлцүүлгийг хийж, 2 дугаар хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Улсын Их Хуралд шилжүүлсэн билээ.

1. Ажлын хэсэг төслийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар.

Хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2023 оны 162 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулан 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 20, 27, 30-ны өдрүүдэд, мөн 11 дүгээр сарын 7-ны өдөр нийт 4 удаа хуралдлаа. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг төсвийн орлогыг нэмэгдүүлэх замаар төсвийн тэнцлийг сайжруулах, төсвийн урсгал зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтын зардалд өөрчлөлт оруулах, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх гэсэн 4 чиглэлээр Улсын Их Хурлын Тамгын газар, Үндэсний аудитын газар, Сангийн яам болон бусад төрийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан ажиллууллаа.

Ажлын хэсгээс Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс ирүүлсэн төсвийн төсөл, дүн шинжилгээ, танилцуулга, санал, дүгнэлт, Үндэсний аудитын газраас Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлттэй танилцаж, Сангийн яамнаас төсвийн төслийн орлого, зарлагыг тооцсон үндэслэл, хөрөнгө оруулалтын

төсөл, арга хэмжээний дэлгэрэнгүй судалгааг гаргуулан авч, хэлэлцэн танилцлаа.

2. Улсын Их Хурлын Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлт, Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын талаар.

Улсын Их Хурлын Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Улсын Их Хурлын гишүүд, төрийн зарим байгууллагаас албан бичгээр ирүүлсэн саналуудыг нэг бүрчлэн судлан үзээд, дараах зарчмыг баримтлан саналын томъёоллыг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна.

1. Байнгын хороодоос Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд гишүүдээс зарчмын зөрөөтэй 6 саналын томъёоллоор санал хураалган, Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байна. Байнгын хорооны хуралдаанаар гишүүдийн гаргасан зарчмын зөрөөтэй саналыг тухайн Байнгын хороо дэмжээгүй бол саналыг ажлын хэсэг дэмжих шаардлагагүй гэж үзсэн болно.

2. Байнгын хороодын хуралдаанаар дэмжсэн боловч гишүүд тодорхой зохицуулалт хийгээгүй, холбогдох хуульд заасан шаардлагыг хангаагүй зарчмын зөрөөтэй саналуудыг ажлын хэсгээс дэмжих боломжгүй гэж үзлээ.

3. Байнгын хороонд болон ажлын хэсэгт албан бичгээр саналын томъёолол ирүүлсэн нийт саналуудаас төсөвт зохицуулалт хийх, төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх, мөн төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн салбар дотроо зохицуулалт хийх саналууд болон зураг төсвийн магадлал хийгдсэн, ирэх жилийн улсын төсөвт бага ачаалал үзүүлэх төсөвт өртөг нэмэгдүүлэх саналуудыг ажлын хэсгийн санал болгон дэмжиж Байнгын хорооны

хуралдаанд танилцуулахаар шийдвэрлэлээ.

4. Байнгын хороонд болон ажлын хэсэгт албан бичгээр саналын томъёоллоор ирүүлсэн нийт саналуудаас магадлал хийгдээгүй, төсөвт өртөг нэмэгдүүлэн төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал өөрчлөх болон бусад гишүүдийн тойрог, бусад салбарын төсвийн зохицуулалт хийж, өөрийн тойрогт хөрөнгө оруулалт тавихаар ирүүлсэн саналуудыг ажлын хэсэгт дэмжих шаардлагагүй гэж үзлээ.

3. Ажлын хэсгээс бэлтгэсэн саналын агуулгын талаар.

Олон жил хуримтлагдсан татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн цалин, тэтгэвэр тэтгэмж, төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2022 оноос өмнөх хуримтлагдсан өр төлбөрийг 20 хувиас доошгүй буюу 92 тэрбум 100 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 20-оос доошгүй хувь буюу 194 тэрбум 300 сая төгрөгөөр, Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг 50-аас доош хувь буюу 256 тэрбум 361,3 сая төгрөгөөр тус тус барагдуулж, улсын төсвийн орлогыг 542 тэрбум 761,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Мөн Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад зааснаас бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар тахлын үед төвлөрүүлээгүй ноогдол ашгийн үлдэгдлийг бүрэн дайчлах замаар улсын төсөвт 48 тэрбум төгрөгийг нэмж төвлөрүүлэх саналыг бэлтгэлээ.

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын нийгмийн даатгалын сан, зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад зардлын. Энэ юу яачихсан байна даа, хө. Хуучин тоогоороо яваад байх юм, бууруулах, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг бууруулж, төсвийн зардлыг 335 тэрбум 261,1 сая төгрөгөөр бууруулах санал бэлтгэлээ.

4.Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх хүрээнд зарим байгууллагын 2016 оноос хойш нэмэгдээгүй цалин нэмэгдүүлэх, 2024 онд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцыг нийгмийн даатгалын санд олгох татаасыг нэмэгдүүлэх, ШЕЗ-ийн даргын болон Боомтын сэргэлтийн үндэсний хорооны мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардал, төрийн албан хаагчдыг сургаж, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагааны зардал, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардал болон бусад шаардлагатай зардлыг нэмэгдүүлэх хүрээнд төсвийн урсгал зардлыг 223 тэрбум 622,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал бэлтгэсэн болно.

5. Хөрөнгө оруулалтын зардлын хувьд төсөл, арга хэмжээний 2024 оны санхүүжих дүн 118 тэрбум 750,2 сая төгрөгийг өөрчилж, холбогдох зохицуулалтыг тусган, та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн даргад баярлалаа.

Дэгийн тухай хуулийн 72-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг танилцуулна гэж заасан байгаа. Түрүүлж Монгол Улсын ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат дарга төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг танилцуулъя. Занданбат даргын микрофоныг өгье. 1 номер.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг 7 зорилтын хүрээнд хянаж үнэлэхэд аудитын зорилго чиглэсэн.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дараах шаардлагад нийцсэн гэж дүгнэж байна. Үүнд:

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн

бодлоготой нийцсэн байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл ДНБ-д эзлэх харьцаа 2024 онд 40,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25 их наяд 289,8 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 34,2 хувь, нийт зарлага 27 их наяд 360,5 тэрбум төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 37 хувь, тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд 70,8 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

3. Монгол Улсын 2024 оны төслийг боловсруулахад Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дараах дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1. Төсвийн төсөлд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ, татварын орлого зэргийг өөдрөгөөр төсөөлсөн нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл үүсвэл төсөвт тодотгол хийх нөхцөлд хүргэж болзошгүй байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүй нь төсвийн зорилго

хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй байна.

3.Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмбэлэх, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан эдийн засгийн бодит үр өгөөжийн тооцоо судалгаа хийх аргачлалыг боловсруулан баталж, Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.11 дэх заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.Гадаад өрийн төсөвт үзүүлэх ачааллыг бууруулах зорилгоор дотоод үнэт цаас гарган төсвийн алдагдлын тодорхой эх үүсвэрийг бүрдүүлэхээр төсвийн төслийг боловсруулсан боловч түүний үр ашгийг нарийвчлан тооцоолоогүй байна.

5. Төсвийн төсөлд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний барилга байгууламжийн ангилалд магадлал хийгдэж байгаа 21, 1 маягаар болон жишиг магадлалаар 153 төсөл, арга хэмжээг тус тус тусгасан байна.

Барилга байгууламжид зураг төсөлд магадлал хийх, худалдан авах ажиллагаа, зохион байгуулах, гэрээ байгуулах, захиалагчийн хяналт болон гэрээний хэрэгжилтийг хангуулах, улсын комисс, барилга байгууламжийг хүлээн авах зэрэг төсвийн хөрөнгө оруулалтын үйл явцад тавих дотоод хяналтын тогтолцоог сайжруулан, субъектив сөрөг нөлөөллийг бууруулах эрх зүйн тодорхой нарийвчилсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газар дараа оны төсвийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барихдаа төрийн албадын байгууллагаас өгч буй дараах зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн барихдаа төсвийн төсөл боловсруулах тухайн үе дэх хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэсэн байх.

Төсвийн төлөвлөлтийн дунд ба урт хугацааны төлөвлөлтийг төсвийн алдагдлыг 2 хувиас бага байлгах.

Эдийн засгийн зохистой харьцааг баримтлан төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчмыг хангаж, төсөвт үзүүлэх гадаад өрийн ачааллыг бууруулж, төлөвлөлтийг сайжруулах.

Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцсэн төсвийн төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаж байх.

Улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төсвийн хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн дүнд өөрчлөлт орж буй шалтгаан нөхцөлд нарийвчилсан судалгаа, дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.

Төсвийн төслийг тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн эсэх хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, орон нутгийн хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлж, удирдан зохион байгуулах.

Хөгжлийн бодлогод нийцүүлсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг бүрэн хэрэгжүүлж, салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдыг нэгдсэн арга зүйгээр хангаж чадавхыг сайжруулах зэрэг болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Ерөнхий аудитор Занданбат даргад баярлалаа.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн талаарх танилцуулгыг

Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна. Жавхлан сайдын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж, иргэдийн бодит орлогыг хамгаалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд улсын эдийн засаг сайжирч, улмаар урт хугацааны хөгжлийн эхний 10 жилийн зорилт болох шинэ сэргэлтийн бодлогоо хэрэгжүүлэх боломж бүрдээд байна. Тиймээс шинэ сэргэлтийн бодлогын гол зорилтын нэг болох хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн төсөв, санхүүгийн багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр ирэх 2024 оны төсвийн төсөлд тусгасан болно. Ирэх оны төсөвт тусгасан онцлог арга хэмжээг дурдвал:

1. Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгодог тэтгэмж, нийгмийн халамжийн асаргааны тэтгэмж, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох тэтгэмжийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү арга хэмжээнд 217,7 мянган төрийн албан хаагч, 499,2 мянган тэтгэвэр авагч, давхардсан тоогоор нийт 146,9 мянган нийгмийн халамжийн

дэмжлэг, туслалцаа зайлигүй шаардлагатай хүн хамрагдах болно.

2. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг ирэх оноос хэрэгжүүлэхтэй холбогдуулан малчдын төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа иргэдийн шимтгэлийг 100 хувь тус тус төрөөс хариуцаж, нийт даатгуулагчдын тэтгэвэр тогтоолгоход баримтлах дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, тэтгэврийн хуримтлалын нөөц санг мөнгөжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын төсөвт төсөлд тусгаад байна.

Боловсролын шинэчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, Политехникийн коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах тэтгэлгийг ирэх оноос олгож эхэлнэ.

Ирэх онд хүүхэд хамгааллын төсвийг хүрэх үр дүн, гүйцэтгэлтэйгээ уялдуулан 80 хувиар нэмэгдүүлж 14,3 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөдөг байна. Энэ нь хүүхдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг хангалттай бүрдүүлэхэд хүрэлцэхгүй хэдий ч салбар хоорондын уялдааг сайжруулах, орон нутгийн санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой хуваарилбал тодорхой үр дүн гарах боломжтой гэж үзэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн”-ийг үргэлжлүүлэн дэмжиж, хүнсний ногоо, газар тариалангийн ажлын явц, бүсийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг технологийн парк, мах, ноос, арьс шир, түүхий эд, хүнс, сүү боловсруулах үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай

арга хэмжээний төсөв болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, зээлийн хүүгийн татаасанд зориулж ирэх онд нийт 223,7 тэрбум төгрөг хуваарилна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн нийгэм, эдийн засгийн үр ашиг, ач холбогдол бүхий төслүүдэд чиглүүлж энэ хүрээнд төсвийн төсөлд нийтдээ 6,1 их наяд төгрөгийн хөрөнгийн зардлыг төлөвлөсөн нь Дотоодын нийт бүтээгдэхүүний 8,2 хувь, нэгдсэн төсвийн нийт зардлын 22,6 хувьтай тэнцэж байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,2 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1050 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Засгийн газрын ажлын хэсэг төсөв өргөн мэдүүлэхийн өмнө бүх аймгуудад ажиллаж, төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдэд иргэдийн саналыг авах, иргэдээр эрэмбэлүүлэх ажлыг анх удаа зохион байгуулсан билээ. Үүний дагуу хот, хөдөөгийн хөгжлийг уртасгах, эрчим хүч, авто замын төслүүдэд зориулж ирэх онд 1,9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 154 төсөл, арга хэмжээний 593,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгаад байна.

Эдгээр төслүүдийг эхлүүлэх төдий бус харин хамгийн багадаа 1 жил, хамгийн ихдээ 3 жилд багтаан хэрэгжүүлж, ашиглалтад оруулах зорилт тавьж, үүний дагуу 2024 онд хамгийн багадаа 30 хувийн санхүүжилтүүдийг тус тус тусгалаа.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг гадаад зээл тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд эдгээрээс томоохон

төслүүдийг дурдвал газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл, Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төсөл, Чойбалсан дулаан цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх төсөл, Улаанбаатар хотын ундны ус хангамжийг сайжруулах болон төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл болон 10 аймагт дулаан станц барих төсөл зэрэг болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан дээрх төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 7 хувьд хүрч, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 25,3 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага 27,4 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал 2,1 их наяд төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2,8 хувь болж төсвийн тусгай шаардлага хангагдаж байгаа болно.

Иймд дээрх ирэх оны төсвийн төсөлд тусгасан арга хэмжээтэй танилцаж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд Жавхлан сайдад баярлалаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу бусад Байнгын хороо болоод Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн байгаа.

Та бүхэнд тараасан байгаа. 1 дүгээрт, Аюулгүй байдал гадаад

бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт байгаа. 2 дугаарт, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт тараагдсан байна. 3-д Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг тараасан байна. 4-д Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, 5-д, Инновац цахим бодлогын байнгын хороо, 6-д Нийгмийн бодлогын байнгын хороо, 7 дугаарт ТББХ, 8 дугаарт Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо санал, дүгнэлт байна. 9-д Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, 10-д Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт байна. 11-д Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтүүд байна.

Байнгын хорооны даргын хувиар эдгээр Байнгын хороод болоод дэд хороодын санал, дүгнэлтийг сонссонд тооцъё. Гишүүдэд тараагдсан байгаа учраас. Тэгээд сонссонд тооцоноор горимын санал гаргаж, санал хураалгая гэсэн саналтай байна. Тэгээд энэ саналаар санал хураалтыг явуулъя. Гишүүд дэмжинэ гэж итгэж байна. Баярлалаа. Санал хураалт.

Ингээд 85,7 хувиар дэмжигдлээ. Ингээд Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссонд тооцлоо.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 162 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг түрүүн санал, дүгнэлтээ танилцуулсан байгаа.

Ингээд хууль санаачлагч болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Чойжилсүрэн гишүүнээр тасалъя. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 2022 оны улсын төсөв дээр хөрөнгө оруулалт нь тавигдаад 340-өөд сая төгрөгөөр

хөрөнгө оруулалтад тавигдсан 1 ажил байгаа юм байна лээ. Тэгээд яг ажлыг нь би сайн санахгүй байна. Тэгээд Буянт тэгш үйлс гэж компани хийгээд тэгээд 40 сая төгрөг нь оны эцсээр бүр 12 сарын хорьдоор болонгуут нөгөө гүйцэтгэлээ өгсөн чинь яам руу бүх хөрөнгө оруулалтууд татаад аваад явчихсан гээд. Тэгээд тэр жилдээ нөгөө хөрөнгө оруулалт бүх зүйл нь тавигдчихсан бүтнээрээ тавигдчихсан. Он дамжаагүй учраас дараа жилд нь ямар ч хөрөнгө оруулалт тавигдаагүй. Тэгэнгүүт тэр хүн 23 оны төсөв дээр 40 сая төгрөг тавиад өгөөч ээ гээд хөөцөлдөөд явсан боловч яам нь бас анхаараагүй үлдээчихсэн юм байна лээ. Тэгээд энэ 40 сая төгрөгөө яаж олж авах вэ гээд Буянт тэгш үйлс компанийн захирал Цэндсүрэн гэдэг эмэгтэй над руу байнга залгаад байх юм. Тэгээд 300 сая төгрөгийг нь авчхаад 40 сая төгрөгөө аваагүй үлдчихсэн юм байна лээ л дээ. Би тэгээд Сангийн яамныхантай бас энэ асуудлаар ярилцсан. Тэгээд үүнийг хэрвээ энэ төсөв дээр тавихаар би зарчмын зөрөөтэй санал гаргамаар байна. Үгүй бол энэ нэг үүнийг нөгөө дундын сандаа авч үлддэг ийм тохиолдлууд байдаг. Тэндээсээ төлөх боломж байдаг юм уу, байдаггүй юм уу? Энэ тал дээр бас Сангийн яамныхан тодорхой хариулт өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хөрөнгө оруулалттай холбоотой, санхүүжилттэй холбоотой, өмнөх онуудад тавигдсан асуудлаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат дарга хариулъя. 3 номер. Албан тушаал, нэрээ танилцуулаарай.

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тэр нь 150 сая төгрөгийн өртөгтэй тийм өв сан, соёлын тийм өргөө барих ажил байсан. Тэгээд тэрнээс нь 40 сая төгрөгийнх нь гүйцэтгэл 20 онд гүйцэт гаргалгүйгээр

тэгээд татагдчихсан юм билээ. Тэгээд энэ асуудлаар уул нь Соёлын яамнаас манайд хандаж, 2, 3 жилийн өмнө ийм ажил хийгдээд хаагдчихсан юм байна. Үүнийг 24 оны төсөл дээр санал нь ирээгүй байгаа юм. Бид нар бас тухайн үед бас хэлж тайлбарлаж байсан. Тэгээд одоогоор төсвийн ерөнхийлөн захирагч дээр нь санал ирээгүй байгаа учраас 24 оны хуулийн төсөл дээр төсвийн төсөл дээр асуудал суугдаагүй байгаа. Таны тэр дундын данс энэ тэр гээд байгаа чинь яг тодорхой төсөл дээр явагддаг байхгүй юу. Тэгэхээр тухайн үедээ тэр дундын данс дээр буюу барьцаа хөрөнгийн дансанд суугаагүй учраас одоо байхгүй байгаа гэсэн үг. Тэгэхээр тэр төсвийн ерөнхийлөн захирагчдын санал ирээгүй учраас энэ удаагийн хуулийн төсөлд суугаагүй байгаа юм.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн нэмж тодруулъя.

Б.Пүрэвдорж: Буянт сум дээр энэ Бямбацогт оо, чиний тавьсан хөрөнгө оруулалт байхгүй юу даа. Тэгээд энэ дээрээ нэг жоохон хөөцөлдөөд өгөөч. Тэр нөгөө нэг АН-ынхан эмэгтэй болохоор тэр аймгийн удирдлагууд нь дээрэлхээд байх шиг байгаа юм. Тэгээд чи бас хамтарч байгаа юм уу, яаж байгаа юм, би сайн мэдэхгүй байна л даа. Тэгээд ер нь байна шүү дээ. Юу яамаар байна. Тэр нэг шийдлийг нь гаргаад өгчих л дөө. Энэ чинь 40 сая төгрөгөөр тэр нэг ядарсан эмэгтэй 100 би 350 гээд буруу хэлчихнэ шүү дээ 150 сая төгрөгийн л ажил юм байна лээ. Тэгсэн юм уу. Тэгвэл тэгээд тэрийг нь яагаад хариуцлагыг нь тооц л доо.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

Ц.Даваасүрэн: Манай Сангийн яамныхан үүнийг бүр ингээд нэг бүрчлэн тэмдэглэж аваад хариулаадхаарай. Манай аймгийн нэг баахан объектуудыг энэ Ерөнхий сайд сая явахдаа нөгөө амласан объектууд байгаа байхгүй юу.

Тэгээд яагаад энэ санхүүжих дүнг нь өөрчлөөд хаячхав. Жишээлбэл, ЭМТ-ийн барилга Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Хатгал 417. Соёлын төвийн барилга 200 Хөвсгөл Ренчинлхүмбэ, тэрбум 1,4 тэрбум, тийм байна. Спорт урлагийн цогцолбор сургууль 320 Хөвсгөл. Үгүй ээ, энэ сургуулийг 2 жил хасаж, 3 жил хасаж байна. Яагаад ингээд хасаад байгаа юм бэ? энэ 3 дахь нь.

Энд бас сая хөдөө аж ахуйн барилгыг амласан, 575. Политехник коллежийн сургуулийг амласан, 217. Драммын театргүй болсон, Драммын театрын барилга дээр 1,8 тэрбумыг бас ингээд байхгүй. Мөн Хөвсгөлийн Хатгал дээр байгаа цэцэрлэгийн барилгын 400 ортой юуны 623 сая бас байхгүй. Үгүй ээ, энэ яагаад биднээс асуухгүй яагаад ингээд манай объектуудыг ингээд бууруулаад байгаа юм. Хэн ямар ийм санал гаргачихсан юм. Би л лав ийм санал гаргаагүй, үүнийг хариул. Хэн нь гаргасан юм. Би ерөөсөө ингэж хөндөөгүй, хэн гаргасан юм. Үгүй ээ, тэрийгээ хариул, хариул. Би ёстой мэдэхгүй юм байна шүү, энэ. Болохгүй шүү дээ. Ингээд Ерөнхий сайдын өөрийнх нь оруулсан юмыг ингэж өөрчлүүлж болохгүй шүү дээ. Тэгээд Сангийн яамныхан үүнийг бас яагаад тэгсэн юм, Ерөнхий сайд өөрөө ингээд оруулчихсан юмыг яагаад өөрчилж байгаа юм, хариулаарай үүнийг.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Даваасүрэн гишүүн ээ, яах вэ, манай тэр хөрөнгө оруулалтынхны ярьж байгаагаар Мөнхбаатар гишүүн энэ төслүүдээс хооронд нь зохицуулж байж, хасаж саяын таны ярьдаг 4 объектын дөрвүүлэнг нь Мөнхбаатар гишүүн тодорхой хэмжээгээр хасаж тавигдсан гэж ажлын хэсэг тэгж байна. Тэгэхээр хэн хасагдсан нь тодорхой байна. Тийм. Үгүй ээ, харин тэгээд тийм санал ирүүлээд манай объект байгаа юм, би тавиулсан объект байгаа юм гээд

хасуулаад авчихаар чинь яах юм. Тийм. Үүнийг би тавиулсан юм, тэгээд би үүнээс хасах ёстой юм гээд л өөрөө тэгсээр байгаад хасаад явчхаж байгаа юм чинь.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя. Даваасүрэн гишүүний микрофон.

Ц.Даваасүрэн: Үгүй ээ, бид нар ингэж ярьсан шүү дээ. Ингээд нэг ялангуяа тухайн тойрог юмнуудыг хоорондоо ярихгүйгээр ингэж шийдэхгүй шүү гэж, болохгүй шүү дээ. Ялангуяа энэ чинь Ерөнхий сайдын өөрийнх нь бүр оруулсан 7 объект байгаа байхгүй юу. Ерөнхий сайдын өөрийнх нь оруулсан. Хэрвээ тэгдэг бол бид нар ч гэсэн тэгээд л өөрчлөөд л, өөрчилнө шүү дээ. Ингээд байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ ажлын хэсэг бас үүнийгээ эргэж хар, энэ болохгүй шүү. Ялангуяа Ерөнхий сайд үүнийг чинь бүр Засгийн газрын хуралдаан дээр бүр анхааруулаад, тэгээд Жавхлан энэ тэр Хүрэлбаатар сайд энэ тэрд үүрэг өгөөд тавиулсан юмнууд нь байна шүү дээ. Тэгээд нөгөөдүүлийг нь хасаад хаячихсан байна шүү дээ, бууруулаад. Ингээд байж болохгүй. Ийм зарчимгүй байж болохгүй шүү дээ. Гол гол. Тэр соёлын Драммын театр, Политехникийн сургууль, хөдөө аж ахуйн барилга, Хатгалын цэцэрлэг, Хатгалын дотуур байр, Цэцэрлэгийн Цагаан нуурын... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Бид Аубакир гишүүн бид 2 энэ нэг замын Өлгий, Сагсай, Улаан хус, Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай зам гэж энэ нэр хүчин чадлыг нь өөрчилсөн байна. Энэ 7 дугаар хүснэгт бичсэн байна лээ. Гэтэл төсөвт өртгийг нь энд нөгөө 46 тэрбум гэдгийг нь 46,8 тэрбум гэдэг нь энд орхигдсон юм шиг байна. Бид олохгүй байна, хараад. Тэр нь хаана бичигдсэн юм бол. 23,1км гэсэн хүчин чадлыг нь

өөрчилсөн байна. Харин төсөвт өртөг нь 46,8 гэсэн тоо энэ дотор харагдахгүй байна. Тэрийг асуумаар байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баделхан гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ, ажлын хэсэг. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн гишүүн асуултад хариулна.

Д.Тогтохсүрэн: 7 дугаар хүснэгт нөгөө цэвэр нэр томъёоны өөрчлөлт байгаа юм. Тэгээд таны нэр томъёоны нөгөө өөрчилсөн нэрээ тавьчихсан байгаа. Төсөвт өртөг нь урд талд нь байгаа та үзээрэй, тэр том жагсаалт дотор. Түүн дотор 46-гаар тавигдсан байгаа гэж байна. Та тэрийгээ олчихоорой.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүн асуултаа асууя.

Ш.Раднаасэд: 2 зүйл байна. Юуны өмнө ажлын хэсэгт баярлалаа. Ямар ч байсан энэ хавдрын эмнэлгийг эхлүүлэх хэмжээний мөнгийг нь ямар ч байсан тавьчихсан байна. Тэгээд энэ хэдэн жил үргэлжлэх бол гэдэгт л их санаа зовж байна. Одоо хавдрын лаборатори гэхэд 10 оноос хойш баригдаж байгаад энэ жил ашиглалтад орсон байгаа юм. Бүтэн 13, 4 жилийн хугацаанд. Энэ томъёолол дээр ингэж болох уу, Тогтохсүрэн дарга аа. Би энэ албаар протоколд бүр үлдээж байгаа юм шүү. Энэ тавьсан мөнгө зөвхөн эхлэх л төдий мөнгө. Тэгэхээр эхлэл гэж оруулмаар байна. Хавдрын эмнэлгийн барилга 2. Эхлэл 2 гээд, тийм.

Тэгээд бас нэг эрх зүйн асуудал орхигдсон, энд. Одоо Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо гээд. Нөгөө дархан цаазтай газар. Өмнө нь 2 газар сонгоод барьсан. нэг нь ус гарсан. нэг нь болоогүй. Ээг нь орчин нь болохгүй байна гэсэн. Одоо ингээд дархан цаазтай газар эмнэлэг барих гэхээр хууль зөрчиж байна, энэ заавал отог барих ёстой гээд ингээд. Ингээд бас нэг гацалт үүсчих вий. Тэгээд

1 ийм юм үүсчих вий гэж би болгоомжлоод байна л даа. Тэгээд урд Зайсангаар хувийн эмнэлгүүд байгаад байгаа, тийм ээ. Нэг тийм эрх зүйн зөрчил үүсчих болгоомжлол байгаад байх юм.

2 дахь юм нь ЭМД-ынхнаас хүмүүс байна уу? Энэ төсвийг юуг бодохдоо санхүүжилтийн юмыг бодохдоо бид нар бас нэг энэ эмнэлэгт нь өөрт нь давхар ачаалал гэдэг юм уу өөрсдийнх нь гарт атгуулах үүднээс нэг юм хийвэл бас болмоор гээд байгаад байгаа юм. Одоо энэ Эрүүл мэндийн даатгалаас байна шүү дээ. ЭМД-ын талаас зөвхөн хавдрын эмчилгээ, оношилгоо гээд тэгэхэд 89 тэрбум төгрөг гарсан байгаа юм. Зөвхөн улсын эмнэлгүүд дээр, энэ оны 9 сарын байдлаар. 89 тэрбум бага мөнгө биш байхгүй юу. Хувийн эмнэлгүүдэд бас нэг 23 тэрбум. Нийлээд бодохоор энэ чинь 110 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалаас гарчхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ даатгалын юмыг энэ нэгдсэн эмнэлэгтэйгээ уях юм. Яаж уяж зохицуулалт хийх вэ гэдэг ийм боломж байна уу? Тэр үүнийг ядаж барилгаа барьчихлаа гэхэд тоног төхөөрөмжөө өөрсдийнхөө хүрээнд эмнэлэг өөрөө шийдээд явах хэмжээний хуримтлал бий болж эхэлж байна шүү дээ. Хавдрын үндэсний төв жишээлбэл даатгалаас жилд хэдэн төгрөг олдог юм, авдаг юм. Оношилгоо, эмчилгээнээсээ зөвхөн. Түүгээрээ зарим өндөр үнэтэй аппаратуудаа худалдаж авах ч юм уу, улам нөгөө даатгалынхаа орлогыг нэмэгдүүлэх, үйлчилгээгээ сайжруулах ийм боломж энд харагдаад байгаа байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг Даваасүрэн гишүүн асуултад хариулъя.

Ц.Даваасүрэн: Раднаасэд гишүүний болгоомжилж байгаа бас зөв л дөө. Яагаад гэвэл зургийг нь хийж байгаа

компани хавдрын эмнэлгийн 900 саяар хийнэ гэж авчхаад 3 тэрбумаар хийнэ ээ гээд суучихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ асуудал шийдэгдэхгүй байтал энэ тавьсан мөнгө чинь ирэх жил ашиглагдахгүй болчихно. Тэгэхээр үүнийг хэрвээ ашиглая гэж бодож байгаа бол эхлээд зургийн асуудлыг ямар нэг хэмжээгээр энэ дээр шийдэж явахгүй бол энэ мөнгө ашиглагдахгүй. Зураггүй юм чинь яаж явах юм, яах вэ зураггүй тавигдчихсан байгаа гэсэн үг шүү дээ, одоо бол. Үгүй ээ тэгвэл одоо шийдчихсэн, шийдчих нь дээр байхгүй юу. Би Чинзоригт хэлсэн шүү дээ. Одоо нэг бол шийдчих ээ, наанаасаа тэр 2,3 нь гэдэг юм уу ингээд тэрбум төгрөгөөр нь тавиад өгчих, зургийг нь. Тэгвэл наадах чинь бүтнэ. Тэгэхгүй бол бүтэхгүй.

2-т, бас Раднаасэд гишүүний хэлж байгаа үндэслэл байгаа юм. Газрыг нь сольчихсон юм байна лээ. Газрын байрилыг нь сольчихсон чинь өнөөдрийн энэ бүх маргааны эхлэл болчихсон байгаа байхгүй юу. Уг нь тэр зургийн компанид та нар энэ 900 саяараа хийнэ гээд амласан юм чинь үүнийгээ хий гэж хэлэх ёстой. Гэтэл нөгөөдөх нь болохоор газар байриил сольсон гэдгээр бас ингээд шалтаглаад байгаа юм байна лээ шүү.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж тайлбар өгье.

Б.Жавхлан: Даваасүрэн сайдтай санал нийлж байна. Хэдүүлээ энэ зургийг нь ер нь бүтнээр нь шийдчих хэрэгтэй юм. Үнэхээр бас яг цаанаасаа тэгээд байгаа бол зовлон л байгаа л юм байлгүй. Тийм учраас сая Хүрэлбаатар сайдтай ярилаа. Хүрэлбаатар сайдын өөрийнх нь нөгөө том багц байгаа шүү дээ. Зураг төсвийн. Түүн дээрээсээ тэр зөрүүг нь шийдчихээж болно. Энэ жил ч шийдэж болно, ирэх жил ч шийдэж болно. Бараг энэ жилийнх дээрээс үлдэгдлээ харж байгаад шийдчихээж болохоор юм байна лээ. Тийм. Тийм ээ, Хүрэлбаатар сайд аа, тийм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн гишүүн. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Раднаасэд гишүүн энэ дээр харин бид нөгөө томъёоллыг өөрчилчихмөөр юм байна лээ. Энэ нэрийг нь. Зураг төсвийг дуусгах ажлыг эхлүүлэх гэдэг хэлбэрээр. Тийм учраас би Раднаасэд гишүүнийг та ингээд зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлдчих ээ. Тэгээд гишүүд үүнийг дэмжээд 3 дугаар хэлэлцүүлэг дээр, 2 дугаар хэлэлцүүлэг дээр энэ Байнгын хороо болон нэгдсэн чуулган дээр олонхын санал авчихвал 3 дугаар хэлэлцүүлэг рүү шууд түүгээрээ суучихна. Тэгээд явах юм бол ажил нь хурдан явагдана гэж ингэж бодож байна.

Г.Тэмүүлэн: Тэгж ойлголоо. Раднаасэд гишүүн нэмж тодруулах юм байна. Раднаасэд гишүүний микрофоныг

Ш.Раднаасэд: Энэ аймаг, сум, нийслэл бүгд л орж л байгаа байх л даа. Эхний 9 сарын байдлаар энэ чинь бараг 199657 хүнд хавдрын оношилгоо, эмчилгээний үйлчилгээ үзүүлсэн байгаа байхгүй юу. Зөвхөн төрийн эмнэлгүүд гэхэд 96,3 тэрбум төгрөг, хувийн эмнэлгүүд гэхэд 29,7 тэрбум төгрөг, нийтдээ ингээд хэчнээн төгрөг болоод байгаа юм бэ, энэ. Бараг 1,2 их арай их наяд биш биз дээ? Арай худлаа байлгүй. Энэ даатгалтай уялдуулж энэ санхүүжилтийн юмыг зохицуулах ийм, энэ Чинзориг сайд байхгүй. Энэ Эрүүл мэндийн даатгалаас хүн байна уу.

Г.Тэмүүлэн: Эрүүл мэндийн яамнаас хүн байна уу. Даатгалаас. Ажлын хэсгийн микрофоныг өгье. Та 4 номер дээр суучих уу? 4 номерын микрофоныг өгье. 1 номер ажлын хэсгийн микрофон.

Хавдар судлалын үндэсний төвийн Ерөнхий захирал Эрдэнэхүү байна. Тэгээд Раднаасэд гишүүний асуусан асуултад

хариулъя. Тэгээд бас дээр нь юуны түрүүнд Монгол хүний эрүүл мэндийн энэ тулгамдсан асуудлыг ойлгож бас онцгойлон авч үзээд энд намайг дуудаж асуулга, тодруулга хийж байгаад хавдартай олон хүмүүсийн өмнөөс баярлалаа гэдгээ илэрхийлье. Төсвийн хуулийн ажлын хэсгийн ахлагч болон Төсвийн байнгын хороонд.

Тэгээд саяын асуулт дээрээ даатгал дээр маань болохоор Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор даатгал дээр ямар өртөг тогтоогдсон байдаг вэ гэхээр тухайн ажилтны эрүүл мэндийн салбарын ажилтны хөлс, ажлын эмнэлгийн хэрэгсэл, эм болон урсгал зардлуудыг багтаасан тийм өртөг тооцогдсон байдаг. Энэ нь 3 жил өөрчлөгдөөгүй яваа. Тийм ч учраас ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж 1 минут өгье. Ажлын хэсгийн 1 номер.

Н.Эрдэнэхүү: Эндээс тусдаа нөгөө хөрөнгө оруулалт хийх эрх нь нээгдсэн байгаа. Хуулийн дагуу. Гэхдээ тийм хэмжээний том хөрөнгө оруулалтыг хийх боломж байхгүй. Эмнэлгүүд хөрөнгө оруулалтыг хийгээд тодорхой тоног төхөөрөмжүүдээ өөрсдөө шийдээд явж байгаа. Тийм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Чойжилсүрэн гишүүн асуулт асууна. Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье. Нэрээ татлаа.

Хүрэлбаатар гишүүн асуулт асууна.

Ч.Хүрэлбаатар: Би зүгээр асуулт ч юу байх вэ дээ, зүгээр нэг ийм л юм байгаа юм. Аудитын дүгнэлттэй нөгөө төсөвт өртөг нэмэх гэж байгаа юунаас нэг Увс аймгийн Давст сумын эмнэлгийг 100 гээд тавьчихсан байх юм. Гүйцээгээд нэг 280-ыг нь нэмчихмээр байх юм, 87-г нь. Тэгээд түүнийг нь дотор нь нэг

зүйлээс хасаад тавиад зохицуулчихъя, зохицуулчихаарай. Тэгэхгүй бол хар аа, юм нь дуусчихсан. Аудитынхаа дүгнэлтийг хүлээгээд л гарчихсан. Тэгээд дүгнэлтээ гаргаад мөнгөө авчихвал нөгөө ажлаа явуулчих гэж байгаа юм. Тийм учраас дотор нь нэг гүйлгээ зохицуулалт хийгээд өгөөрэй.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүн асуулт асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Би нэг юм тодруулах гэсэн юм. Энэ ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрөөтэй саналын 3 дугаар хавсралтын дун чинь өргөн барьсан төсөл дээр нэмэгдэж байгаа дүн биз дээ, тийм биз. Тэрийг би тодруулах гэсэн юм. Яагаад гэвэл би өөрийнхөө санал дээр дотроо юу зохицуулалт хийсэн болохоор өмнө өргөн барьсан дүн дээрээ 675 саяыг нэмье гэсэн тийм санал оруулсан. Үүнийг би тодруулчихмаар байна.

2 дугаарт, энэ Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо Засгийн газрын тогтоолоор татан буугдсан байгаа. Татан буугдсантай холбоотойгоор төсөвт үндэсний хороонд суулгасан байсан 25,5 тэрбум төгрөгийн төсвийг нийслэлд шилжүүлж байгаа юм байна. Тэгээд энэ шилжиж байгаа дүнг нийслэлээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос хасуулах зарчмын зөрөөтэй санал гаргая гэсэн би саналтай байгаа юм. Одоо болохоор зүгээр урсгал зардал дээр нь суулгачихсан байгаа юм. Тэгэхээр энэ эцсийн үр дүнд ямар ч ялгаа байхгүй. Зүгээр улсын төсөвт төвлөрүүлэх дүнгээс нь 25,5 тэрбумыг хасуулах тэгж санал оруулж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүний асуусан асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулах уу? Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье, ажлын хэсэг хариулна.

Д.Тогтохсүрэн: 3 дугаар хавсралт дээр биччихсэн байгаа. Өмнө нь

төсөв өртөг нэмэгдүүлэхийг нь, ард нь санхүүжих дүнг нь биччихсэн байгаа, Амартүвшин гишүүн ээ. Тийм учраас төсөвт өртөг нэмэгдүүлэх саналыг өмнө нь биччихсэн учраас тэрийгээ энэ зөвхөн нэмэгдүүлэх санал нь. Цэвэр зөрүү нь гэж ойлгоорой. Тэр нийслэлийн 25 аравны тэр дүн нь нэг жаахан өөрчлөгдсөн. 25,3 болсон, 4 орчим болсон. Тэгээд энэ ингээд байгаа юм. Дэгийн хуулиар шилжүүлж болохгүй байгаа юм. Дэгийн хуулийн 70.8 дээр юугаа биччихсэн гэхээр зэрэг нь татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргана гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл та татвар бууруулах 25,3 тэрбум төгрөгийн татвар гаргах санал гаргавал наадах чинь татвар байхгүй юу. Өөрөөр хэлбэл наадах чинь нийслэл одоо улсын төсөв дээр 270 тэрбум төгрөг төвлөрүүлж байгаа газар. Тэр 270 тэрбум төгрөгөөс нь 25 тэрбум төгрөгийг нь бууруулж байгаа гэсэн үг. Тэгэхээр та нөгөө талд нь зарлага дээр мөн 25,3 тэрбум төгрөг хамтад нь бууруулах ёстой. Ийм зарлага хамтад нь гарах гээд байгаа учраас энэ дэгийн хуулийн дагуу хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно гэж байгаа юм. Тийм учраас, тийм учраас энэ дээр санал хурааж болохгүй байсан учраас үгүй ээ юу, орлого бууруулж болохгүй байсан учраас бид нар нийслэлийн урсгал зардал дээр буюу нийслэлийн орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардалд нь зориулж 25,3 тэрбум төгрөг тавьсан юм. 3 тэрбум төгрөг тавьсан юм. Тэгэхээр энэ 2-ыг хамтад нь гаргана гэдэг дэгийн хууль байгаа учраас энэ дэгийнхээ хуулиар яваа юм.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж. Батжаргал гишүүн тодруулах зүйл байна. Батжаргал гишүүний микрофоныг өгье. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: ЭМЯ-ныхан, тэр хавдрын захирал нэг анхааралтай сонсоодхооч. Хавдар судлалын үндэсний

төвийн 2 дугаар барилга, Улаанбаатар Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо гээд мөнгө тавьсан байна. Энэ Засгийн газраас өргөн барьсан төсөл дээрээ дэд бүтцийнх нь ажлыг хийнэ гээд Төв аймаг, Сэргэлэн гээд орчихсон яваад байгаа шүү. Хэн чинь надад хавдрынх нь эмнэлэг гэж хэлсэн шүү дээ, Чинзориг чинь. Тэгвэл тэгж ойлгож байгаа юм байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөвтэй холбогдуулж урьдчилан бичгээр томьёолж ирүүлсэн саналуудыг хэлэлцэж эхэлье.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн зүгээс төсвийн төсөвтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй томьёолол бэлтгэн ирүүлсэн байгаа. Та бүхэнд зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг бас тарааж өгсөн. Ингээд саналаа урьдчилан ирүүлсэн бичгээр томьёолж ирсэн саналуудаар санал хураалтыг явуулж эхэлье.

Нэг. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураалтыг явуулна.

Нэг.Төсвийн тэнцэл сайжруулахтай холбоотой төсвийн орлого нэмэгдүүлэх санал байна.

1.Төсвийн орлого нэмэгдүүлэх санал: Дүн нь 590 тэрбум 761,3 сая төгрөг.

1.1.Олон жил хуримтлагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулж, төсвийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, төрийн үйлчилгээний зардлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах

зорилгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2022 оноос өмнөх хуримтлагдсан өр төлбөрийг 20-оос доошгүй хувь буюу **92,100.0 сая** төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өр төлбөрийг 20-оос доошгүй хувь буюу **194,300.0 сая** төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг 50-аас доошгүй хувь буюу **256,361.3 сая** төгрөгөөр тус тус барагдуулж, улсын төсвийн орлогыг **542,761.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Адъяаа, Анужин, Аубакир, Бат-Амгалан, Батсуурь, Баярсайхан, Дамдинням, Оюунчимэг, Пүрэвдорж, Сэргэлэн, Туваан, Тэмүүлэн, Цогтбаатар, Цэрэнпунцаг, Н.Энхболд, Ж.Эрдэнэбат. Цаашид ажлын хэсэг гэх.

1.2. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад зааснаас бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, цар тахлын үед төвлөрүүлээгүй ногдол ашгийн үлдэгдлийг бүрэн дайчлах замаар улсын төсөвт **48,000.0 сая** төгрөгийг нэмж төвлөрүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүд ээ, анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал 66,7 хувиар дэмжигдлээ. Санал хураалтад 15-аас 10 гишүүн оролцлоо.

Хоёр.Төсвийн зардал нэмэгдүүлэх, бууруулах санал:

2.1. Төсвийн зардал бууруулах санал: Дүн: **335,261.1 сая төгрөг**

2.1.1. Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 2.51 хувиар буюу **309,522.9 сая** төгрөгөөр бууруулах;

2.1.2. Орчны бохирдлыг бууруулах

үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг **25,738.2 сая төгрөгөөр** бууруулах;

2.2. Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх санал: **Дүн: 223,622.3 сая төгрөг**

2.2.1. Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны урсгал зардлыг **1,000.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.2. Улсын төсвөөс Говьсүмбэр аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг **1,000.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.3. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгаж чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын орчныг бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг **20,738.2 сая төгрөгөөр**, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг **5000.0 сая төгрөгөөр** тус тус нэмэгдүүлэх;

2.2.4. Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын Сум, багийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Төв аймагт **300.0 сая төгрөг**, Ховд аймагт **300.0 сая төгрөгөөр** тус тус нэмэгдүүлэх;

2.2.5. Аймгийн номын сангийн номын фондыг баяжуулах зорилгоор Соёлын сайдын төсвийн багцын номын зардлыг Төв аймагт **100.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.6. Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг баяжуулах зорилгоор Боловсрол,

шинжлэх ухааны сайдын төсвийн багцын номын зардлыг **175.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.7. Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын 2016 оноос хойш нэмэгдүүлээгүй цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын цалингийн санг **233.0 сая төгрөгөөр**, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын цалингийн санг **640.5 сая төгрөгөөр**, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын цалингийн санг **11,100.1 сая төгрөгөөр**, Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцын цалингийн санг **198.1 сая төгрөгөөр**, Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын цалингийн санг **17,506.1 сая төгрөгөөр** тус тус, нийт **29,677.8 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.8. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг **800.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.9. Ховд аймгийн агаар, хөрсний бохирдлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын урсгал зардлыг **500.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.10. Удирдлагын академид төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг **3,561.7 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.11. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардалд зориулан Шадар сайдын төсвийн багцын урсгал зардлыг **500.0 сая төгрөгөөр** нэмэгдүүлэх;

2.2.12. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг **8,108.0 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.13. 2024 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг **140,661.6 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх;

2.2.14. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг **11,200.0** төгрөгөөр нэмэгдүүлэх.

2.3. Хөрөнгийн зардалд өөрчлөлт оруулах санал: **Цэвэр өөрчлөлтийн дүн: 118,750.2 сая төгрөг**

2.3.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 9 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг хэрэгжилт, гүйцэтгэлийн явцтай уялдуулан **98,000.0 сая** төгрөгөөр саналын томъёоллын 1 дүгээр хавсралтын дагуу бууруулах.

2.3.2. Саналын томъёоллын 2 дугаар хавсралтад тусгагдсан **800,889.4 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **245,012.9 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 212 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах.

2.3.3. Төсвийн төсөлд тусгагдсан 25 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **30,537.8 сая** төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **21,025.7 сая** төгрөгөөр саналын томъёоллын 3 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **203,858.7 сая** төгрөгөөр саналын томъёоллын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу, 11 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **19,991.1 сая** төгрөгөөр саналын томъёоллын 3 дугаар хавсралтын 3 дахь хэсэгт

тусгасны дагуу тус тус нэмэгдүүлэх, мөн саналын томъёоллын 3 дугаар хавсралтын 4 дэх хэсэгт тусгасан 2 төслийн төсөвт өртгийг **34,992.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны санхүүжих дүнг **3,000.0 сая** төгрөгөөр бууруулах.

2.3.4. Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулиар өмнө нь батлагдан хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн магадлалд хийсэн Үндэсний аудитын газрын аудитын дүгнэлтэд үндэслэн саналын томъёоллын 4 дүгээр хавсралтын 1 дэх хэсэгт тусгагдсан **284,078.1 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **18,604.3 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүнтэй 51 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төсөлд шинээр нэмж тусгах, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томъёоллын 4 дүгээр хавсралтын 2 дахь хэсэг дэх 61 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 115,698.0 сая төгрөгөөр, 14 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **10,489.1 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх, мөн төсвийн төсөлд тусгагдсан саналын томъёоллын 4 дүгээр хавсралтын 3 дахь хэсэг дэх 2 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнг 738.6 сая төгрөгөөр тус тус бууруулах.

2.3.5. Төсвийн төсөлд тусгагдсан 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг **7,773.8 сая** төгрөгөөр, 2024 онд санхүүжих дүнг **5,873.8 сая** төгрөгөөр саналын томъёоллын 5 дугаар хавсралтын 1 дэх хэсэгт тусгасны дагуу, 51 төсөл, арга хэмжээний 2024 онд санхүүжих дүнг **71,820.7 сая** төгрөгөөр саналын томъёоллын 5 дугаар хавсралтын 2 дахь хэсэгт тусгасны дагуу бууруулах.

2.3.6. Саналын томъёоллын 6 дугаар хавсралтад тусгагдсан **32,480.3 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй, **16,939.9 сая** төгрөгийн 2024 онд санхүүжих дүн бүхий 15 төсөл, арга хэмжээг 2024 оны төсвийн төслөөс

хасах.

2.3.7. Төсвийн төсөлд тусгагдсан төсөвт өртөг болон 2024 онд санхүүжих дүнд нөлөөлөхгүйгээр 33 төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадлыг **саналын томъёоллын 7 дугаар хавсралтад** тусгасны дагуу өөрчлөх. Санал гаргасан. Ажлын хэсэг.

Нэмэлт санал байна. Ажлын хэсэг Тогтохсүрэн. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Энэ ингэх юм, дарга аа. Бид нар өдөр ажлын хэсгээр тань дээр саяын өгсөн 1, 2, 3 дахь санал бол өдөр бид нар нөгөө ажлын хэсэг дээр ярьсан санал байгаа юм. Ажлын хэсэг дээр ярилцсанаас хойш ажлын хэсэг дээрээ тохирсны дагуу 3 санал тооны хувьд өөрчлөгдсөн юм дарга аа, тэрийг би уншихъя. Та энэ миний уншсанаар санал хураалгана гээд тохироорой.

Нэг. Төсвийн зардал бууруулах саналын 2.1.1 дэх саналыг доор дурдсанаар өөрчлөх:

2.1.1. Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 1.88 хувиар буюу 320 тэрбум 416 сая төгрөгөөр бууруулах,

Хоёр. Төсвийн урсгал зардал нэмэгдүүлэх саналын 2.2.3 дахь саналыг доор дурдсанаар өөрчлөх:

2.2.3. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгаж чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэл Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг 25,388,2 сая төгрөгөөр БОАЖ-ын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг 350 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх,

3. Төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэх саналыг 2.2.14 дэх саналыг доор дурдсанаар өөрчлөх:

2.2.14. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор аймгуудын тогтмол зардлыг 11 тэрбум 200 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн энэ 3 саналыг түрүүний таны уншсан саналыг, энэ 3-ыг засаж хураалгах ёстой шүү гэдгийг би албан ёсоор санал хэлж байгаа юм. Өглөө ажлын хэсэг дээр уншсанаар та уншсан. Одоо үүгээр уншиж байгаа юм. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүн асуулт.

Б.Чойжилсүрэн: Тэмүүлэн дарга аа, энэ бууруулах санал чинь байна шүү дээ, 335 тэрбум 261,1 сая төгрөг байна. Бууруулах санал нь. Нэмэгдүүлэх санал байна шүү дээ, хөрөнгийн зардал нь 118, урсгал нь 223 гээд ингэхээр хоорондоо баланслахгүй байна шүү дээ. Санал хураахын өмнө үүнийг хөрөнгийн зардал чинь энэ томъёонуудад өсөгдөөд энэ чинь өөрчлөлт 118, 750 гээд биччихсэн. Урсгал зардлын чинь өөрчлөлт 223 тэрбумаар нэмэгдэж байгаа. Тийм. Түүнийгээ шалгаарай.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн гишүүн асуултад хариулах уу.

Д.Тогтохсүрэн: Ингэж барьж байгаа. Сая Чойжилсүрэн гишүүн байв уу, дуу нь. Урсгал зардлыг бууруулах нийт 363 тэрбум 925,9 сая, урсгал зардал нэмэх 245 тэрбум 175,6 сая, хөрөнгө оруулалт 118 тэрбум 750,3 сая. Ингээд баланс нь барьж байгаа юм. Баланс нь 363,925.9 дээр барьж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн ахлагч тайлбар өглөө.

Амартүвшин гишүүн саяын асуулт асууя.

Г.Амартүвшин: Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга аа, Тоогий дарга. Сая таны унхсан санал байгаа шүү дээ, Тоогий дарга, Тогтохсүрэн дарга аа. Одоо ингээд нийслэл дээр нөгөө үндэсний хорооны 25,3-ыг зардал дээр нь нэмж байна гэж байна шүү дээ тийм ээ. Гэтэл нийслэл 24 онд улсын төсөвт төвлөрүүлэх дүн нь өөрчлөгдөхгүй байхгүй юу. Өөрөөр хэлбэл, нийслэл 25,3 тэрбумын шинэ орлого хаанаас, хаана нэгэн газраас олгох хэрэгтэй болчхож байгаа байхгүй юу. Шаардлагатай. Татвараа нэмэх юм уу, яах юм. Тэгэхээр нийслэлийн улсын төсөвт төвлөрүүлэх юуг нь 25,3-аар нь бууруулаад өг өө л гээд байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол нийслэл чинь 25,3 тэрбумаар орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай болоод байна шүү дээ. Татвараа нэмэх юм уу, яах юм? Харин тийм, би саналаа оруулахаар санал хураалгадаггүй байна л даа. Тэгэх юм бол нийслэл энэ орчны бохирдлын асуудлыг хариуцахгүй гэж байгаа шүү. Хэрвээ ийм байдлаар яах юм бол.

Г.Тэмүүлэн: Сангийн яам Санжаадорж дарга асуултад хариулъя. 4 номер.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр нөгөө улсын төсөвт төвлөрүүлэх орлогын шилжүүлгийг болохоороо Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн дагуу зохицуулдаг. 56 дугаар зүйл нь өөрөө төсвийн шатлал хоорондын харилцаа гэж байгаа юм. Тэгээд энэ дээр юу гэж заасан байдаг вэ гэхээр орлогын шилжүүлгийг гаргаж ирэхдээ орлого, зарлага 2-ын зөрөөгөөс ашгаас нь 70 хувийг нь үлдэх орлого болгож, тухайн нэгжид нь үлдээгээд, 30 хувийг нь улсын төсөвт татна гэсэн тийм зохицуулалтаар томъёогоор орлогын шилжүүлгийг гаргаж ирж байгаа юм. Шууд орлогын шилжүүлгийг хасна гэж томъёолох болохгүй болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл томъёогоор гарч ирж

байгаа учраас. Тэгэхээр орлого дээр нь нэг бол зохицуулалтаа хийнэ, нэг бол зарлага дээр нь зохицуулалтаа хийхээс өөр аргагүй болчхож байгаа юм. Тэгэхээр зарлага дээр нь яг хассан тоогоор нь буцаагаад зарлага дээр нь тэр тоогоор нь л нэмэх л зохицуулалт л ажлын хэсгээс орж ирж байна гэж ойлгож байгаа. Тийм.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Томъёог ойлгож байна. Одоо яг энэ саналаар 25,3 тэрбумын зардлыг нийслэл дээр нэмж байгаа. Тэгэхээр 24 онд нийслэлээс улсын төсөвт төвлөрүүлэх орлого нь энэ хэмжээгээр буурах юм уу, үгүй гэвэл нийслэл 25,3 тэрбумаар л ямар нэгэн байдлаар орлогоо нэмэгдүүлэх шаардлагатай болчхож байгаа байхгүй юу. Гэтэл нийслэл чинь 24 онд бид нар шинэ түгжрэлийн хууль, шинэ төслүүд энэ тэр гээд л баахан зардалтай байдаг. Яаж 25,3 тэрбумыг дахиж нийслэлийн орлого дээр нэмэх юм? Хаанаасаа бид нар тэрийг нэмэх юм. Үгүй ээ, үгүй, харин тэгвэл одоо өргөн барьсан энэ төслөөр нийслэлээс улсын төсөвт төвлөрүүлэх орлого чинь энэ хэмжээгээр багасна гэсэн үг үү? Тэгж ойлгож болох уу?

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Санжаадорж дарга хариулах уу? 4 Номер, ажлын хэсгийн 4 номер.

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Яг энэ дүнгээр нь 25 тэрбумыг улсын төсвөөс хасаад, 25 тэрбумаар нь орлогын шилжүүлгийг хасахын тулд илүү өндөр дүнгээр буюу нөгөө 30, 70-ынхаа харьцаагаараа дахиад илүү өндөр дүнгээр улсын төсөв талаасаа хасаж байж, саяын 25 тэрбумаар урсгал шилжүүлэх нь хасах

боломжтой болно. Илүү өндөр дүнгээр хасах хэрэгтэй болно гэсэн үг.

Г.Тэмүүлэн: Чойжилсүрэн гишүүн тайлбарлах юм уу, тайлбар хэлэх юм уу. Чойжилсүрэн гишүүн. Чойжилсүрэн гишүүн нэмж тайлбарлая, тайлбар өгье.

Б.Чойжилсүрэн: Энэ ингэсэн. Яг Амартүвшин гишүүн санаа зовоод байгаа ингэж ойлгогдсон юм, Тэмүүлэн дарга аа. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгая. 25,6 тэрбумаас 350 саяыг нь Байгаль орчин сайд дээр үлдээгээд, 25,3-ыг нь хот руу шилжүүлж өгье гэдэг ийм ойлголтоор Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо 11 сарын 01-ний өдөр Засгийн газрын хуралдаанаар татан буугдсан байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр ЗГХЭГ-аас таны нэр дээр мөн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын хувьд миний юу албан бичгээр тоотоор явсан. Сая Санжаадорж даргын тайлбарлаж байгаагаар хуулийн зохицуулалт болохгүй байгаа бол үүнийг Байгаль орчны сайд дээр ч юм уу, аль нэг сайд дээр тавиад бүрэн дүнгээр нь, дараа нь нийслэлийн хүсэлтээр гэдэг юм уу ойлголцоод эрх шилжүүлэх ийм л гарц үлдэж байгаа. Тэгэхгүй ингээд үүгээр нь хураачих юм бол саяын юу. Ингэхгүй бол байна шүү дээ. Энэ 25 тэрбум чинь аль ч үгүй, хотод ч байхгүй ийм болно шүү.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга та санал хэлэх үү? Тогтохсүрэн даргын микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Тэгэхээр ингэчихье. Ерөөсөө 25 тэрбум 783-аа, 25 тэрбум 738,2 сая төгрөгөө шүүд бүгдийг нь Байгаль орчны сайдын багц дээр тавьчихъя. Эднийх больчихсон юм, байгаль орчин чинь бохирдлын хороо чинь байгаль орчин дээр оччихсон юм байна. Тэгэхээр байгаль орчин дээр нь тавьчихъя.

Чойжилсүрэн дарга аа, байгаль орчин дээр оччихсон юм гээ биз дээ, сайд аа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн даргын микрофоныг. Чойжилсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Ийм болно, Амартүвшин гишүүн ээ. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо татан буугдсан учраас хэрвээ Эрчим хүчний сайдын төсвийн багц дээр тавигдах юм бол Сангийн яам санхүүжүүлэхэд хүнд болно. Яагаад гэвэл хуультай зөрчилдөнө. Тэгэхээр яг энэ орчны бохирдлыг бууруулах үндсэн чиглэл нь Засгийн газрын тухай хууль болон Төсвийн тухай хуулиудаараа зохицуулалт нь Байгаль орчны сайд дээр байна гэсэн үг. Тэгэхээр Байгаль орчны сайд руу бид нар шилжүүлэхээс ондоо гарцгүй гэсэн. Эрчим хүчний сайдын төсөв дээр суулгачих юм бол дараа нь Сангийн яам юу санхүүжилт гаргаж. Тэгээд ийм шүү дээ, хотын гишүүд ээ. Яг энэ Байгаль орчны сайдын чиглэлд одоо байгаа хуулийнхаа хүрээнд байгаль орчны бохирдолтой холбогдолтой ийм зардлыг л санхүүжүүлэхээр Байгаль орчны сайд эрхээ Нийслэлийн Засаг дарга руу шилжүүлнэ ээ гэсэн үг шүү дээ. Ондоо. Тэгэхээр үүнийг засаж ойлголцсон нь дээр.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Ерөнхийдөө. Тогтохсүрэн дарга та базаад томъёоллыг нь хэлээдэх.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр ийм томъёоллоор явчихъя гэж байна. Амартүвшин гишүүн, Сандаг-Очир гишүүн. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо татан буугдаж чиг үүргийг шилжүүлсэнтэй холбогдуулан тэгээд тодорхой хэлэх гэж байна. Нийслэл Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардал болох 25 тэрбум 738,2 сая төгрөгийг БОАЖ-ын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны Байгаль орчны сайдын

төсвийн багцыг нэмэгдүүлэх гээд тавьчихъя.

Гол тавьж байгаа нь юу гэж бичих вэ гэхээр ингээд биччихсэн байгаа юм шүү. Нийслэл Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг Байгаль орчин сайдын багцын ийм зардал дээр ингээд тавьчихна. Болж байна уу? Яг тэгж тохирно. Болно оо, болно, болно. Үгүй ээ, үгүй таны 500-г нэмчихье, тэгэх үү. Ингэчихье бас нэг юм нь тэр 2.2.9 дээр байгаа Бямбацогт, биш ээ уучлаарай 2.2.9 дээр байгаа Ховд аймгийн агаарын бохирдлыг бууруулах 500 сая төгрөг байгаа юм. Үүнийг бас нийслэлийнх нь 25,7 тэрбум, Ховд нь 500 тэрбум бүгдийг нь нийлүүлээд тэд болгоод 500 сая, бүгд нийлээд тэд гээд тэр дүнгээр нь Байгаль орчин сайдын багцын энэ зардлыг нэмэгдүүлсүгэй гээд л редакц хийчихнэ. Болж байна уу? Яг ийм байдлаар ойлголцоод уншихвал бид нар энэ дээр нь 2.2.9, 2.2.3 хоёрыг нэгтгээд саяын байдлаар ойлголцоод томъёоллыг нь засаад хийгээд маргааш чуулганд оруулчихъя л гэж байна.

Г.Тэмүүлэн: Бямбацогт гишүүн. Санал хэлэх эрхтэй. Та Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ Төсвийн байнгын хорооны гишүүн байж болно оо, тийм. Гэхдээ Их Хурлын гишүүн байгаа. Наад Их Хурлын тухай хууль тэгээд Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль бүгдийг нь би бичсэн юм. Их Хурлын гишүүн тийм үү, хэдийд ч аль ч Байнгын хороо, аль ч тийм үү, ажлын хэсэг дээр саналаа хэлэх эрхтэй. Төсвийн байнгын хороон дээр тийм үү, санал гаргах эрхгүй, санал хураалтад оролцох эрхгүй, энэ ялгаануудыг бас манай Тамгын газрынхан бас энэ хүмүүс бас мэдэж аваарай. Тийм. Саналаа хэлэх эрхтэй. Тий. Тэгээд ингээд үгээ хэлчихье гээд хэлүүлэхгүй шоовдорлоод байгаа юм уу, хаашаа юм.

Энэ сая Тоогий даргын 2.2.3, 2.2.9-ийг нэгтгэж болж байгаа юм. Би үүнийг дэмжиж байгаа ингээд явчихъя. Гэхдээ тэр Ховд аймгийн агаар орчны бохирдлыг бууруулах 500 сая бол байгаль орчны багцын Сангийн юу сайдын багцаас Ховд руу эрх нь шилжээд явчихна. 20 тэрбум нь нийслэл хот руу эрх нь шилжих нь байна. 25 биш 5 тэрбум нь бас үндсэндээ тийм. Өөрийнх нь бас тийм үү, зөвхөн хотынхоос гадна бас орон нутгийн байгаль орчны бохирдлыг бууруулах асуудлууд байгаад байна шүү дээ. Тийм болохоор ингээд 20 тэрбум нь үндсэндээ бүгд 25 тэрбум 738 дээр нэмэх нь 500 гэдэг чинь 26 тэрбум 338-аар байгаль орчны багц дээр суугаад, түүнээс 20 тэрбум нь хот руу, 5 тэрбум нь Байгаль орчны сайдын багцад үлдэнэ, 500 сая нь Ховд руу шилжинэ. Ийм агуулгаар л ойлгоод явчихъя.

Г.Тэмүүлэн: Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ төсвийн юун дээр ба манай Байнгын хорооны гишүүд жсоохон болгоомжтой хандаад янзалмаар байгаа юм. Булгантуяа гэж нэг нөхрөөс болоод ингээд энэ төсөв задрах болчихлоо, болчихлоо шүү дээ. Би Булгантуяад хэлээд байгаа юм. Чиний хариуцлагагүй үйлдлээс болоод энэ Засгийн газрын төсөв чинь задарлаа шүү гээд байгаа, Булгантуяаг. Чи тэр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг ижил мөнгөн дүнгээр нэмэх бодолтой байсан бол наад бодлоо одоо биш тэр Засгийн газар төсөв бүрдүүлээд Их Хуралд оруулж байх үедээ яриад наадхаа оруулж байх ёстой юм байхгүй юу. Тэгээд 1 өдөр гэв гэнэтхэн өглөө босонгуутаа ийм сонин юм яриад ингээд төсвийг ингэж үймүүлж болохгүй ээ, Булгантуяа. Чи орон гаран байж болно. Төрийн бодлого чиний орон гаран бодлоор ингэж явж болохгүй шүү дээ, Булгантуяа. Ингэж төрийг самарч болохгүй. Төсвийг ингэж үймүүлж болохгүй.

Би 2 юм хэлэх гээд байгаа юм. Би үүнийг чинь тэр 2,5 хувиар бууруулна гэдэг чинь нэлээн эсэргүүцсэн, эсэргүүцэхээс ч арга байхгүй. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг оруулаад 2,5 хувийг бууруулна гэх дээр манай даатгалын санд чинь 2 их наяд төгрөг. Энэ чинь үндсэндээ дийлэнх нь 70 орчим хувь нь цалин, шимтгэл байдаг юм. Энэ чинь болохгүй ээ гээд байгаа юм. Тэгээд одоо би, тэгээд нийгмийн даатгалын сангаа 2,5 хувиар бууруулах тэр зардалд оруулахгүй гээд заль хэрэглэсэн байгаа юм. Нохойтой хог. Залуугаараа муу юу, муу юм сурчихсан юм. Би тэрийг нь ярьж байгаад Жавхлан сайдтай ярьж байгаад өглөө наадхыг чинь яриад, наад ажлын хэсэг чинь санал хураагаад алх цохичихсон шүү дээ. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг 2,5 хувиар бууруулахгүй гээд. Тэгээд тэрийг чинь болиулъя гэсэн. Тэгэхээр нь наана чинь 1,6 хувь болж байгаа юм. Үүнийг чинь би зөвшөөр. Гэхдээ би нөгөө талдаа 2 юм зөвшөөрч байгаа юм. Улсын Их Хурлын хууль батлагдсантай холбогдон гарах тогтоолд, тогтоолд, тогтоолд тэр одоо Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжтэй хуультай холбоотой заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан заалт оруулбал би зөвшөөрье гэж хэлсэн юм. Тэгээд тэрийг бүлгийн дарга Жавхлан хоёр хоёулаа зөвшөөрсөн юм.

Сая тэгэх нь ээ, Их Хурлын Тамгын газрын дэд дарга гээд нэг нөхөр хууль яриад сүрхий нөхөр гэв гэнэтхэн өнөөдрөөс сэрсэн юм байна, хууль яриад болохгүй гээд солиороод энд оруулаагүй байна. Тэгэх юм бол би үүнийг хүлээж авахгүй. Ёстой жадлан эсэргүүцнэ. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа Жавхлан сайдтай аймгийн орон нутгийн нэгдсэн эмнэлгүүдийн тогтмол зардлыг орон нутгийн төсөв хариуцах ёстой, энэ орохгүй байгаа юм. Аймгийн нэгдсэн эмнэлгүүд, дүүргүүдийн эмнэлгүүдийн тогтмол зардлыг Жавхлан сайд оруулж

өгье гэсэн юм. 24 тэрбум төгрөг оруулж өгье гэсэн юм. Одоо болохоор нохойтоод 11 тэрбум төгрөг л гээд боломж нь энэ гээд ингэж бие биеэ хуурч тоглохгүй ээ. Төсөв батална гэдэг чинь чиний тэгж дураараа ярьдаг тийм тоглоом биш, Булгантуяа. Төсөв батална гэдэг чинь энэ бол улсын бодлого. Сайд хүний бүтэн жилийн бодлого. Энэ бүтэн жилийн бодлого чиний нэг өдрийн, энэ самуунаас болж ингэж төсөв задарч болохгүй. Би тэр Их Хурлын тогтоолд тэр орон нутгийн эмнэлгүүдийн тогтмол зардлыг шийдэхтэй холбоотой заалт орохгүй бол, 2 дугаарт, Жавхлан сайд надтай ярьсан. Тэр тогтмол зардал аймаг, дүүргийн тогтмол зардалтай 24 тэрбум төгрөгтэй холбоотой асуудлыг шийдэх асуудлыг оруулахгүй бол би үүнийг би энэ албан тушаалаа өгөөд ч хамаагүй би үүний төлөө тэмцэнэ. Булгантуяа. Ингэж төрийг сүйрүүлж болохгүй. Ингэж төсвийн бодлогыг үймүүлж болохгүй. Ингэж манай бүлгийн дарга, Сангийн сайд, сайд нартайгаа худлаа нэг юм тогтчихоод, тэгээд дараа нь ингэж мурьж болохгүй шүү дээ. Энэ чинь хүүхдийн тоглоом биш шүү дээ. Энэ чинь бүтэн жилийн бодлого, энэ чинь дараа нь төрийн бодлого төрийн бодлого. Би сайдаар очоод 9 жил ажиллаж байхдаа үүнийг чинь бодож бодож боловсруулж байж, чам шиг нэг ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Засгийн газрын гишүүд. Засгийн газрын гишүүд ээ, төсвийн төсөл өргөн баригдсаны дараа, төсвийн төсөл өргөн баригдсаны дараа Засгийн газрын гишүүд нэмж бичгээр санал ирүүлсэн. Засгийн газар дотроо энэ асуудлаа ярилцацгаагаарай. Одоо болно.

Чойжилсүрэн гишүүн.
Чойжилсүрэн гишүүн.

Б.Чойжилсүрэн: Тэмүүлэн дарга аа, ийм байна. Сая Тоогий даргын унисанаар санал хураагаад, 2 дугаар хэлэлцүүлэг яваад тэгээд чуулган руу орчихвол буцах гарцгүй болно оо. Одоо би нэг горимын санал гаргаж байна. 10

минут завсарлая. Тэгээд энэ Сангийн яам, Тоогий даргын сая уншсан 2-ыг хуулийн зөрчилгүй баталъя. 10 минут завсарлая.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгийн дарга энэ асуудлуудыг тоог нь нягтлаад наад цэгцлэх энэ ажлыг та бас хийх хэрэгтэй байна. Ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн дарга.

Д.Тогтохсүрэн: Чойжоо сайд аа. таны ярьж байгаа үнэн. Тэгээд ингэж, хэрэв тэр 25 тэрбум төгрөгийн миний хэлснээр 25 тэрбум төгрөгийн санал ингээд хураагдчихсаны дараа ийм юмаар санал хураалгах гэж байгаа юм. Энэ саяын санал дэмжигдсэнтэй холбоотойгоор энэ тооцооллыг хийж, нэгдсэн чуулганд оруул гэдгээр хурал даргалагчаас чиглэл өгөөд ингээд явчихад болно гэж үзэж байгаа юм. Тэгэхээр тэр 25. Үгүй ээ, харин тэгэхээр ингэж байна шүү дээ. Тэгэхээр тэр 25 тэрбум төгрөгтэй холбоотой асуудал чинь тэр тооцоолол хийх эрхийг нь өгчих гээд байна шүү дээ. Энэ Байнгын хорооноос эх үүсвэртэй нь хамт шийд гэдэг эрхийг өгчих гээд байгаа юм. Тэгэхгүйгээр ингээд завсарлага авах би шаардлагагүй ээ. 25 тэрбум төгрөгтэй энэ заалт одоо санал хурааж шийдэгдээд л дараа нь Байнгын хорооны даргаас “ингэ” гэдэг чиглэлийг ажлын хэсэгт өгчихөөр тэрийгээ бас цохиод бас шаардлагатай гэвэл санал хураалгачих. Тэгээд явчихад би болно гэж байгаа юм. Тэгж үзэгдэхгүй ээ гэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Ажлын хэсгийн дарга өөрөө томъёолоод цэгцлээд. Тэгээд саналын томъёоллыг уншсан. Тогтохсүрэн дарга, Бямбацогт гишүүдийн саналын томъёоллуудыг нэгтгээд саяын уншсан байдлаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Байнгын хорооны гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт 92,9 хувиар дэмжигдлээ.

Тогтохсүрэн гишүүний санал дэмжигдсэн тул Тогтохсүрэн дарга, та саналаа хэлье.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр Байнгын хорооны дарга аа. Саяын санал дэмжигдсэнтэй холбогдуулаад энэ саяын нөгөө төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэх болон бууруулах зардал 2 хамтдаа хураагдсан учраас ялангуяа тэр нийслэлийн 25 тэрбум 738,2 сая төгрөгтэй холбоотой асуудлаар орлого, зарлагын тооцооллын зөрөө гарах магадлал байгаа юм. Тийм учраас би хурал даргалагчаас үүнтэй холбогдуулж энэ нийслэлийн энэ зардалтай холбогдуулж, орлого, зарлагын гарч байгаа тооцооллыг хийж, зохицуулж чуулганд оруулна гэдэг ийм байдлаар та нэг алх цохичих хэрэгтэй байгаа юм. Тийм.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Тэгэхээр саяын саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулаад энэ орлого, зарлагын тооцооллыг хийж, хянаж, зохицуулалтыг хийх чиглэлийг бас ажлын хэсэгт өгч байна. Тогтохсүрэн даргад.

Гурав. Зарчмын бусад саналууд байна.

3.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах

3.1.1. Төслийн 10 дугаар зүйлийн “1,231,447.7 сая төгрөг,” гэснийг “1,231,447.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт 92,9 хувиар дэмжигдлээ

3.1.2. Төслийн 11 дүгээр зүйлийн “2,788,332.7 сая төгрөг,” гэснийг “2,788,332.7 сая төгрөг байна.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

85,7 хувиар дэмжигдлээ.

3.2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах.

3.2.1.Төслийн 1 дүгээр хавсралтын гарчгийг “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт” гэж, мөн хавсралтын 11.1 дэх хэсгийн “70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих” гэснийг “70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт” гэж, 11.2 дахь хэсгийн “Хөтөлбөр” баганын “11.2.1, 11.2.2” гэсэн дугаарыг “11.1.3, 11.1.4” гэж, 16.2 дахь хөтөлбөрийн 16.2.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “Илтгэх хуудас” гэснийг “Илтгэх хуудас-1” гэж, 20.5.1 дэх хөтөлбөрийн 20.5.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “7” гэснийг “300/7” гэж, 20.6.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “цэвэрлэгээний ажлын хэмжээ” гэснийг “цэвэрлэгээ” гэж, 21.1.2 дахь хөтөлбөрийн “Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн” баганын “өргөжихийн хирээр” гэснийг “өргөжүүлж” гэж, 21.2.1 дэх хөтөлбөрийн “2024 оны зорилтот түвшин” баганын “5.0” гэснийг “6.0” гэж, 23.5.1 дэх хөтөлбөрийн 23.5.1.5 дахь хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “45,700.0” гэснийг “45,000.0” гэж, 23.8.1 дэх хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт баганын “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 26.6.1 дэх хөтөлбөрийн 26.6.1.5 дахь хэсгийн “Хэмжих нэгж” гэсэн баганын “жин” гэснийг “хувь” гэж, 28.3.1 дэх хөтөлбөрийн 28.3.1.1 дэх хэсгийн “2024 оны зорилтот түвшин” баганын “51.1” гэснийг “65.3” гэж, 29.3.1 дэх хөтөлбөрийн 29.3.1.1 дэх хэсгийн “хууль” гэснийг “хуулийн төсөл” гэж, 36.1.1 дэх хөтөлбөрийн 36.1.1.1 дэх хэсгийн “хамрагдаж” гэснийг “хамрагдсан хүмүүст” гэж, 37.1.1 дэх хөтөлбөрийн 37.1.1.1, 37.1.3 дахь хөтөлбөрийн 37.1.3.1, 37.1.3.3 дахь хэсгийн “хувь”

гэснийг “явц” гэж, 38.1 дэх хэсгийн “70501 Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг” гэснийг “71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр” гэж тус тус өөрчлөх, хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орсонтой холбогдуулан дугаарлалтын өөрчлөлт оруулах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

78,6 хувиар дэмжигдлээ.

3.2.2.Төслийн 1 дүгээр хавсралтын 11.2 дахь хэсгийн “70104 Ерөнхийлөгч, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын удирдлагын судалгаа шинжилгээ” гэснийг, мөн хэсгийн “11.2” гэсэн дугаарыг, 28.1 дэх хэсгийн 28.1.2 дахь хөтөлбөр буюу “Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилт, хүрэх үр дүнг 28.1.2.1, 28.1.2.2 дахь хэсгийн шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 28.4 дэх хэсгийн 28.4.1 дэх хөтөлбөрийн 28.4.1.3 дахь хэсгийн “Дорнод үйлдвэрлэл технологийн паркийн бүтээн байгуулалтын явц” гэсэн шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгж, суурь он, суурь түвшин, 2024 оны зорилтот түвшингийн хамт бүхэлд нь, 34.1.1 дэх хөтөлбөрийн 34.1.1.1 дэх хэсгийн “мянгаар” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

85,7 хувиар дэмжигдлээ.

3.2.3. Төслийн 9.1.3 дахь хөтөлбөрийн “Шалгуур үзүүлэлт” баганын “төлөвлөгөөний” гэсний дараа “тухайн оны” гэж, 29.7.1 дэх хөтөлбөрийн 29.7.1.3 дахь хэсгийн “нээсэн” гэсний дараа “хүүхдэд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

85,7 хувиар дэмжигдлээ.

3.3. Бусад санал.

3.3.1. Орлого нэмэгдүүлэх, урсгал зардал болон хөрөнгийн зардалд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлого, зарцуулах зардалд болон орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх орлого, орон нутагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг саналын томъёололтой уялдуулан тооцоолол хийж, хуулийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

85,7 хувиар дэмжигдлээ.

3.3.2. Төсөлд зүйл, заалт нэмэгдэх, хасагдах, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнд өөрчлөлт оруулах, нэр, хүчин чадал, байршлыг өөрчилсөнтэй уялдуулан хуулийн төслийн дугаарлалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дугаар, хэрэгжих хугацаа, эдийн засгийн ангилал, Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд холбогдох өөрчлөлтийг оруулах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт 78,6 хувиар дэмжигдлээ.

3.3.3. Төсөлд шинээр тусгагдсан төсөл, арга хэмжээний төслийн кодыг Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээс бэлтгэн төслийн 2 дугаар хавсралтын “Төслийн код” баганад харгалзуулан тусгах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт 71,4 хувиар дэмжигдлээ.

3.3.4. 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хонины ноос, тэмээний ноос, сарлагийн хөөврийн килограмм тутамд тооцон мөнгөн урамшуулал олгохоор төсвийн

тооцоололд тусгагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолын холбогдох заалтад өөрчлөлт оруулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

78,6 хувиар дэмжигдлээ.

3.3.5. Төсвийн шинэчлэл болон төсвийн тооцоололд өөрчлөлт орсонтой холбоотой, мөн Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын томъёололтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

85,7 хувиар дэмжигдлээ.

Дөрөв.Бусад Байнгын хорооноос ирүүлсэн зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын “VI.1.8.Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/, төсөвт өртөг 2,325.0 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 2,325.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг 374.1 сая төгрөгөөр бууруулж, “Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг /Булган аймаг, Рашаант сум, Элсэн тасархай/, төсөвт

өртөг 374.1 сая төгрөг, 2024 онд санхүүжих дүн 374.1 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээ шинээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Анандбазар. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдгээр санал хураах нь байна шүү. Санал хураалт.

Санал хураалт 85,7 хувиар дэмжигдлээ.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10.Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ийн зардлыг 200.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын музейн засварт 2024 он, 200.0 сая төгрөг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрэм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдгээр санал хураах нь байна. Санал хураалт.

Санал хураалт 71,4 хувиар дэмжигдлээ.

3. Хууль зүйн байнгын хороо

1. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын 10.3.2.1 Хууль. Тийм байна. Уучлаарай, тийм байна.

2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XIV.3.10. Соёлын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ийн зардлыг 400.0 сая төгрөгөөр бууруулж, төсөлд “Сэлэнгэ аймгийн соёлын салбарын тоног төхөөрөмжид 2024 он, 400.0 сая төгрөг” гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрэм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй,

дэмжээгүйг дэмжье гэдгээр санал хураана. Санал хураалт. Байнгын хорооны гишүүд анхааралтай байгаарай.

85,7 хувиар дэмжигдлээ.

3. Хууль зүйн байнгын хороо.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын 10.3.2.1. Хууль зүй дотоод хэргийн салбарын барилга байгууламжийн их засварт тусгасан 6,4 тэрбум төгрөг дотор Гадаадын иргэн, харьяатын газрын баруун бүс дэх газрын үйлчилгээний барилгын нэмэлт ажлын төсөвт 423,8 сая төгрөгийг хуваарилуулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн. Пүрэвдорж гишүүн санал гаргах юм байна. Гаргасан саналтай холбоотой санал гаргах юм байна. Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Сая Төсвийн байнгын хорооны даргын уншсан тэр саналыг би хэлэлцүүлгийн явцад буцаад татаж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Саналаа гаргасан гишүүн саналаа буцаад татаж байна. Санал хураах шаардлагагүй боллоо.

2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын 10.2.2.1. Хил хамгаалах салбарын их засварын санхүүжих дүн 310 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын зардлаас 310 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй. Хууль зүйн байнгын хороо дэмжээгүй саналыг дэмжье гэдгээр санал хураах. Хоёуланг нь татах юм уу. Та саналаа хэлчих. Пүрэвдорж гишүүн бас татаж байгаа юм байна. Пүрэвдорж гишүүн микрофон дээр үгээ хэлээрэй.

Б.Пүрэвдорж: Миний Хууль зүйн байнгын хороо дээр гаргасан саналууд хэлэлцүүлгийн явцад зарим зүйл нь дэмжигдсэн, зарим зүйл нь өөр байдлаар шийдэгдсэн учраас гурвууланг нь татъя гэсэн саналтай байна.

Г.Тэмүүлэн: Ингээд Хууль зүйн байнгын хороо дээр гараад дэмжигдээгүй 3 саналаа Пүрэвдорж гишүүн гурвууланг нь татаж байгаа юм байна. Тэгэхээр санал хураалгах шаардлагагүй боллоо.

Пүрэвдорж гишүүн санал гаргаж байгаа юм байна. Зарчмын зөрөөтэй саналын томъёоллын хуудас ирүүлсэн байна. Зарчмын зөрөөтэй саналын томъёолол нь:

1. 2018-2023 оны хооронд 6 болон 7 жилийн цалингийн дунджаар тэтгэврээ бодуулсан 58 мянган иргэний тэтгэврийн нөхөн олговор 93 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт суулгах. Бусад бууруулах санал буюу зардал хасах санал нь нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын нийгмийн даатгалын сан, зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 0,76 хувиар буюу 93 тэрбум төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Пүрэвдорж гишүүн. Пүрэвдорж гишүүн саналаа танилцуулах уу? Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: 2017 онд Монгол Улс ОУВС-д, сангийн хөтөлбөрт хамрагдсан. Хэд хэдэн үүрэг авсан. Тэгээд 2020 онд энэ хөтөлбөртөө амжилттай хэрэгжлээ гэж үзэж энэ хөтөлбөр дууссан байгаа. Тэгээд эндээс хэд хэдэн санхүүгийн болон бусад үүргээсээ яг тухайн үед хэрэгжиж байсан тэр валютын сангийн хөтөлбөртэй холбоотой үйл ажиллагаанаасаа татгалзсан. Тэгэхдээ 2, 3 асуудал үлдчихээд байгаа юм. Тэр нь юу байсан бэ гэхээр 2018 оноос эхлээд 6

жилээр, 19 оноос хойш 7 жилээр цалингийн дунджаар тэтгэврээ тогтоох, тогтоолгох ийм арга хэмжээнд хамрагдсан. Нийтдээ 58 мянган иргэн энэ хуулийн хэрэгжилтэд хамрагдаж, 6, 7 жилээр тэтгэврээ цалингийн дунджаар тэтгэврээ бодуулсан. Тэгээд 2023 оны 07 сарын 01-нд батлагдсан Нийгмийн даатгалын багц хуулиар 2023 оноос тэтгэврийг тогтоохдоо 5 жилийн цалингийн дунджаар тогтоохоор болсон. Тэгэхээр энэ нэг хэсэг зурвас хугацаанд буюу 2018 оноос 2023 оны хооронд нийтдээ 58 мянган иргэн 7 жил, 6 жилээр бодогдож, тэтгэврээ бодуулж бас хохирсон ийм хүмүүс байгаа. Энэ хүмүүс 24 оны 01 сарын 01-нээс тэтгэврээ 5 жилээр буцааж бодуулна. Ингэсний үр дүнд нэг 800 мянган төгрөгийн тэтгэврээ авч байгаа хүн 1 сая 50 мянган төгрөгийн тэтгэврээ авах ийм боломжийг бүрдүүлэх юм.

Тэгэхээр энэ хэсэг хүмүүс төрийн бас буруутай үйл ажиллагаанаас болж хохирч үлдэх ёсгүй ээ. Тэр хүмүүсийн нөхөн олговрыг олгох ийм зайлиггүй шаардлага гарчхаж байгаа юм. Тийм учраас 2018-2023 оны хооронд 6 болон 7 жилээр тэтгэврээ бодуулсан тэр хүмүүсийн нөхөн олговорт, 58 мянган иргэний нөхөн олговорт 93 тэрбум төгрөгийг зайлиггүй олгох шаардлагатай байгаа. Тийм, энэ нэг одоо буцааж нөхөх, 2024 оны төсвөөс нөхөх боломж нь төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зардлыг 0,76 хувиар бууруулах юм бол энэ 93 тэрбум төгрөг бүгдээрээ төлөгдөх ийм боломж нь бүрдэх юм. Тийм учраас Байнгын хорооны гишүүд амьд бурхад болсон ахмадуудыгаа бодоод энэ саналыг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Пүрэвдорж гишүүн зарчмын зөрөөтэй саналын томъёолол гаргалаа. Саналын томъёоллыг та бүхэнд унисан байгаа. Ванал хураалтыг явуулъя. Санал хураалт, Байнгын хорооны гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

38,5 хувиар дэмжигдсэнгүй.

2. Одонтуяа гишүүн гаргасан санал байна. Одонтуяа гишүүний саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Сумын төв доторх 1,5 км хатуу хучилттай зам, Архангай, Хайрхан сум, 1.5 тэрбум төсөвт өртөгтэй 2024 онд 500.0 сая төгрөг нэмэх, санхүүжих дүн, бууруулах зардал нь Хуулийн төслийн 2 дугаар хавсралт дахь IX.1.3.1 дэх гаалийн шинэчлэл төслийн 2024 онд санхүүжих дүнгээс 500.0 сая төгрөг бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа гишүүн гаргасан байна. Санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

61,5 хувиар дэмжигдлээ.

Өөр санал гаргах гишүүд байна уу? Байнгын хорооны гишүүд.

3 дахь нь хэн гаргасан, Пүрэвдорж гишүүн гаргасан юм уу. 2020 оны төсвийн тухай хуулийн XII.1.2.59-т заагдсан өв соёл, хүндэтгэлийн өргөө, Ховд, Үенч сумын үлдэгдэл санхүүжилтийг 40 сая 924 мянган төгрөгөөр 2024 оны оны төсөвт тусгах, бууруулах санал нь “Шинэ сэргэлт” Ховд, төслийн тоног төхөөрөмж Ховдыг 40 сая 924 мянган төгрөгөөр санхүүжих дүнг бууруулах. Санал гаргасан Пүрэвдорж гишүүн. Санал хураалт.

Аймаг дотроо зохицуулалт хийж байгаа юм байна. Пүрэвдорж гишүүн тийм ээ. Санал хураалт.

Өөр гишүүд санал байхгүй биз. Санал хураалтыг хаалаа шүү.

Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл

мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн нэгдсэн хуралдаан танилцуулна.

Ингээд Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

22.29 цаг

Дараагийн асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулснаар байгаа.

Тэгээд ажлын хэсгийн ахлагч горимын санал гаргах нь байна. Тогтохсүрэн гишүүнд микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Энэ төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх гэж байгаа юм, гишүүд ээ. Тэгээд төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх дээр зэрэг сая нөгөө тэр нийслэлийн 25 тэрбумаас эхлээд нөгөө тооцоолол жаахан өөрчлөгдсөн. Тийм учраас би ямар санал гаргах гэж байгаа юм гэхээр энэ асуудал чинь нөгөө эцсийн тоонууд байдаг, төсвийн хүрээний мэдэгдэл. Тийм учраас нэг 10 минутын завсарлага, Байнгын хороо 10 минут завсарлаад тэр хооронд нь манай ажлынхан, ажлын хэсгийнхэн ажиллаад тоонуудаа нэг дахиж нягтлахгүй бол болохгүй болоод байгаа юм. Тийм учраас би нэг 10 минут завсарлуулах ийм горимын санал гаргаж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэгвэл Байнгын хорооны хуралдааныг 10 минут түр завсарлуулж байна. Баярлалаа.

ЗАВСАРЛАГА.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдааныг үргэлжлүүлье.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүн танилцуулснаар байгаа.

Ингээд ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн санал дүгнэлтийг танилцуулна. Тогтохсүрэн гишүүний микрофоныг өгье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Хууль тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Улсын Их Хурлын даргын 2023 оны 162 дугаар захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэнгээр ахлуулан 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсан. Ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 20, 27, 30-ны өдрүүдэд, 11 дүгээр сарын 07-ны өдөр нийт 4 удаа хуралдсан байна. Ажлын хэсгээс дараах өөрчлөлтийн саналуудыг бэлтгэлээ.

Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүллээ. Мөн нэгдсэн төсвийн алдагдлын хэмжээг бууруулсан. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх

алдагдлын хэмжээг 2 хувь болгосон. Зарлагын хэмжээг мөн тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэн саналын томъёоллуудыг бэлтгэсэн байж байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан баярлалаа.

Г.Тэмүүлэн: Тогтохсүрэн гишүүнд баярлалаа.

Ингээд хуулийн төсөл болоод ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Ингээд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс 1 санал зарчмын зөрөөтэй саналын томъёолол байгаа. Унишж танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “25,289.8” гэснийг “25,855.1” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “34.2” гэснийг “34.9” гэж, Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ 2024 онд “-2,070.8” гэснийг “-1,505.4” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “-2,8” гэснийг “-2.0” гэж, Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2024 онд “6,170.4” гэснийг “6,273.3” гэж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2024 онд “8.3” гэснийг “8.5” гэж, Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ 2024 онд “2,389.6” гэснийг “2,351.9” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг явуулъя. Байнгын хорооны

гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтыг явуулъя. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор дэмжье гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалт 80 хувиар дэмжигдлээ.

Ингээд төсвийн хүрээний мэдэгдэл өөрчлөгдсөнтэй холбогдуулаад төсвийн төслийг бас та бүхэн нягтлах, нэг бүрчлэн нарийвчилж үзэж хараарай гэдэг бас чиглэлийг Байнгын хорооноос өгч байна.

Ингээд санал хураалтыг явуулж дууслаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн дарга Тогтохсүрэн гишүүн нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Ингээд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

23.42 цаг

Ингээд өнөөдрийн Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал хэлэлцэж дууссан байна.

Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Баярлалаа та бүхэнд.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

П.ОЮУНГЭРЭЛ